

ЭМНЕСТИ
ИНТЕРНЭШНЛ



2009 | ОНЫ ЖИЛИЙН
ТАЙЛАН



МОНГОЛЫН ЭМНЕСТИ ИНТЕРНЭШНЛ
www.amnesty.mn

ЭМНЕСТИ ИНТЕРНЭШНЛ

Эмнэсти Интернэшнл нь Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглал болон бусад хүний эрхийн олон улсын гэрээ, баримт бичигт заасан хүний эрхийг дэлхийн хүн бүрт эдлүүлэх чиглэлээр ажилладаг дэлхий даяарх хүний эрхийг хамгаалагчдын хөдөлгөөн юм.


Хүний бүхий л эрхийг хамгаалахын төлөөх өөрийн үйл ажиллагааныхаа хүрээнд бие махбод, сэтгэл санаагаар бүрэн бүтэн байлгах буюу чөлөөтэй сэтгэн бодох, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, ялгаварлан гадуурхалтаас ангид байх зэрэг эрх, эрх чөлөөг ноцтой зөрчихөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох зорилгоор судалгаа хийх ба үйл ажиллагаа явуулж, бодитой арга хэмжээ авдаг.

Ингэхдээ дараах үндсэн чиглэлд тулгуурлаж кампанит ажил явуулдаг. Үүнд:

- Хүний эрхийн зөрчил үйлдэгсэдтэй хариуцлага тооцохыг уриалах
- Хүний эрхийг үр дүнтэйгээр хамгаалахыг засгийн газруудаас шаардах
- Хүний эрхийн олон улсын гэрээ хэлэлцээрүүдэд нэгдэхийг уриалах
- Хүний эрхийн боловсрол олгох сургалт, сурталчилгаа явуулах зэргийг дурьдаж болно.

Эмнэсти Интернэшнл нь дэлхийн 150 гаруй улс оронд 2.2 сая гаруй гишүүд дэмжигчидтэй бөгөөд тэднийхээ хандив, тусlamж, татвараар санхүүждэг.

МОНГОЛЫН ЭМНЕСТИ ИНТЕРНЭШНЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ХҮРСЭН ГАЗРУУД



МОНГОЛЫН ЭМНЕСТИ ИНТЕРНЭШНЛИЙН БҮЛЭГ, ГИШҮҮДИЙН ТОО

1	Бүлгийн нэр	Гишүүдийн тоо
1	Залуучууд	228
2	Оюутан	406
3	Сурагч	153
4	Багш нар	39
5	Хуульчид	70
6	Эмэгтэйчүүд	99
7	Эрэгтэйчүүд	26
8	Сэтгүүлчид	41
9	Чөлөөт	64
10	Эмч нар	44
11	Үйлдвэрчний Эвлэл	20
12	Урлаг	11
13	Парламент	6
14	Багануур	35
15	Дархан	30
16	Эрдэнэт	50
	Нийт	1322

МОНГОЛЫН ЭМНЕСТИ ИНТЕРНЭШНИЙ УДИРДАХ ЗӨВЛӨЛ



Дэлхий даяар хүний эрхийг хамгаалах үйлсэд манлайлагч манай Эмнести Интернэшнл улирч буй 2009 онд олон улс, бус нутаг, орон нутгийн түвшинд хүний эрх, эрх чөлөөг хамгаалах талаар өргөн цар хүрээтэй ажиллагаа явуулж, зохих үр дүнд хүрлээ. Тухайлбал цаазаар авах ялыг халсан улс орнуудын тоо нэмэгдэж, зэвсэглээр хөөцөлдөх явдлыг бууруулах талаар хэд хэдэн дорвигийт алхам хийгдлээ. Байгаль орчныг хамгаалах, дулаарлын үр дагаврыг хохирол багатай давах асуудлыг дэлхийн улс орнуудын эрх баригчдын сонорт хүргэх чадсан, хүйсээр ялгаварлах явдлыг тодорхой хэмжээгээр бууруулж чадлаа гээд олон ололтыг дурдаж болно.

Мөн 2010-2016 оны шинэ Уялдаат стратегийг баталж, өмнөх стратегиэс шинэ стратеги руу шилжих шилжилтийн үед ажиллах тусгай төлөвлөгөөг хөдөлгөөний хэмжээнд хэлэлцүүллээ.

Монголын Эмнести Интернэшнл дээрх бүх арга хэмжээнд тодорхой хэмжээгээр оролцохын сацуу өөрийн орны онцлогт тааруулсан үйл ажиллагаа явууллаа. Бид ЭИ-ийн шинэ Уялдаат Стратегийг батлахад өөрийн дуу хоолойг өргөхийн хамт шилжилтийн энэ үед ажиллах олон улсын төлөвлөгөөнөөс Монголын нөхцөлд тохирсон хувилбарыг сонгоход гишүүд та бүхэн оролцсонд баяртай байна. 2009 оны онцлог бол олон улсын төвийн шинжээч, мэргэжилтний баг 2 удаа манай дээр ажиллаж, залуучуудын маань үйл ажиллагааг үнэлж, “Би эндээс хаачих вэ: 2008 оны 7 дугаар сарын 1-ний үйл явдлын сургамж” тайллан гаргасан явдал бөгөөд олон улсын төв манай МЭИ-ийг анхааралдаа авч, бидний ажил үйлсэд дэмжлэг үзүүллээ.

Та бид “Хүнийг хүндэл” хэмээх ядуурлын эсрэг, эдийн засаг нийгэм соёлын эрхийг хамгаалах кампанит ажлаа олон түмэнд хүрэхүйцээр эхлүүлээд байна.

2010 онд хүний эрх, эрх чөлөөг ханган баталгаажуулахын төлөө урьдын адил эрч хүчтэй, зорилготой ажиллаж чадна гэдэгт итгэлтэй байна.

**Хүндэтгэн мэхийн ёсолсон Р. Янжмаа
Удирдах зөвлөлийн дарга**



**М.Чимэддорж, Шинэ Иргэншил
дээд сургуулийн тэргүүн дэд
захирал,
Удирдах Зөвлөлийн дэд дарга**



**Б.Энхтуяа, өмгөөлөгч, нотариатч,
Хуульчдын бүлгийн ахлагч,
Сан арвижуулалт хариуцсан
Удирдах зөвлөлийн гишүүн**



**С.Ганчимэг, Монгол – Энэтхэгийн
хамтарсан сургуулийн сургалтын
менежер,
Багш нарын бүлгийн ахлагч, Санхүү
хариуцсан Удирдах зөвлөлийн
гишүүн**



**Ц.Монгол, Монголын
Өмгөөлөгчдийн Холбооны
гишүүн өмгөөлөгч,
Бүлэг, гишүүнчлэл хариуцсан
Удирдах зөвлөлийн гишүүн**



**Ш.Анхмаа, ЗТБХБЯАм, Авто
замын төслийн зохицуулагч,
Кампанит ажил хариуцсан Удирдах
зөвлөлийн гишүүн**



**А.Отгончимэг, Японы Хүүхдийг
Ивээх сангийн төслийн ажилтан,
Хүний эрхийн боловсрол
хариуцсан Удирдах зөвлөлийн
гишүүн**



**Г.Гангамөрөн, Сэтгүүлч, “Төгс
гарц” боловсролыг дэмжих
сангийн тэргүүн, Хэвлэл мэдээлэл
хариуцсан Удирдах зөвлөлийн
гишүүн**



**Д.Оюунномин, Сэтгэл зүйч,
Залуучууд хариуцсан Удирдах
зөвлөлийн гишүүн**

2009 онд Монголын Эмнести Интернэшниий удирдах зөвлөл нь ээлжит 6, ээлжит бус 5 хурлыг зохион байгуулж байгуулагын бодлого, төлөвлөгөө, тайлан, цаг үеийн тулгармсан асуудлыг авч хэлэлцээн бөгөөд энэ хугацаанд 21 шийдвэр гаргаж, бүх ажлыг хэсгийг байгуулан ажилласан байна. ОУНБДНГ-аас ирсэн Үнэлгээнийн баг болон хүний эрхийн шинжээч нартай ажлын уулзалт хийж, тайланг нь сонслоо. Хэвлэл мэдээлээр ЭИ-ийг төлөөлэх, олон улсын болон үндэсний хэмжээнд зохиогдож буй хурал семинаруудад суух, сан арвижуулах, кампанит ажлын нээлт, хаалтын үйл ажиллагаануудад ҮЗ-ын гишүүд аль болох хүйсийн тэнцвэрт байдлыг хадгалан идэвхитэй оролцож хувь нэмрээ орууллаа.

ХЯНАЛТЫН ЗӨВЛӨЛ



Д.Энхбаяр, өмгөөлөгч,
нотариатч,
Монголын Эмнести
Интернэшнлийн Хяналтын
зөвлөлийн дарга



Т.Түвшинтулга, Хууль зүйн
үндэсний хүрээлэнгийн эрдэм
шинжилгээний ажилтан,
Хяналтын зөвлөлийн гишүүн



Л.Галбаатар МУИС – ийн Хууль
зүйн сургуулийн IV курсын
оюутан,
Хяналтын зөвлөлийн гишүүн

МОНГОЛЫН ЭМНЕСТИ ИНТЕРНЭШНЛИЙН ГҮЙЦЭТГЭХ ТОВЧОО



Б.Алтантuya, Монголын
Эмнести Интернэшнлийн
гүйцэтгэх захирал



Г.Амарзаяа, Кампанит ажлын
зохицуулагч



Э.Отгончулуун, Кампанит
ажлын зохицуулагч



Т.Ариунаа, Санхүүгийн ажилтан
болон Сан арвижуулах ажилтан



П.Мөнхжаргал, Өсөлт хөгжил
хариуцсан зохицуулагч

Цаг болон мэдлэгээ хандивлагч сайн дурын ажилтнууд

Сайн дурынхан

Монголын Эмнести Интернэшнлийн Сайн дурынхан нь хүний эрхийг хамгаалах, түгээн дэлгэрүүлэх, хүний эрхийн боловсрол олгох их үйлсэд сургалт сурталчилгаа, кампанит ажил зохион байгуулах, холбогдохмэдээллийгорчуулах, түүнийг түгээх, тараах материал бэлдэх, гишүүд дэмжигчидтэй харилцах зэргээр өөрийн үнэт цагаа харамгуй зарцуулж, дундаршгүй мэдлэг чадвараа үнэ хөлсгүйгээр зориулдаг гишүүд, дэмжигч, хүний эрхийн идэвхитнүүд юм. 2009 онд Монголын Эмнести Интернэшнл байгууллагад гадаадын 2, Монголын 30 гаруй сайн дурын ажилтан урт болон богино хугацаагаар ажиллаа.

Б.Энхжаргал



ШУТИС-ийн 2 дугаар курсын оюутан. 2009 онд Монголын Эмнести Интернэшнл элсэн, бүхий л үйл ажиллагаа, кампанит ажлуудад идэвхтэй оролцсон. 13 дугаар сургууль, Цагдаагийн академид Эмнести Интернэшнлийг танилцуулах өдөрлөг, сан арвижуулах үйл ажиллагаанд оролцсон. Гишүүд дэмжигчидтэй харилцах, кампанит ажлын бэлтгэлд сайн дураараа ажилаж, үнэт цагаа зориулдаг.

Я. Мөнхчимэг



Монголын Эмнести Интернэшнлийн Эмэгтэйчүүдийн бүлгийн ахлагч, "Хобби" сургуулийн багш. 2008 онд Эмнести Интернэшнл гишүүнээр элссэн. "Эмэгтэйчүүдийн эрх ба Монгол дахь феминизм" кино хэлэлцүүлэг, "Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг таслан зогсоо", "Хүнийг хүндэл", "Эрүүдэн шүүхийн эсрэг" "Хүний эрхийн парад"-д "Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг таслан зогсоо" кампанит ажлын зохицуулагчаар ажилласан. НҮБ-ын Залуучуудын Зөвлөх хорооноос зохион байгуулсан "Мянганы хөгжлийн зорилтууд ба залуучууд" ярилцлагад оролцсон.

Т.Мөнхсуурь



МУИС-ийн 2-р курсын оюутан. 2008 онд Эмнести Интернэшнл элссэн. 2009 оны 12-р сараас эхлэн эрэгтэйчүүдийн бүлгийн ахлагчаар ажиллаж байгаа бөгөөд Эрүүдэн шүүхийн эсрэг, Цаазаар авах ялыг халах, Эмэгтэйчүүдийн хүчирхийллийн эсрэг кампанит ажил, Олон улсын оюутны

эрхийн өдөр, Эрх чөлөөний парад, Хүнийг хүндэл кампанит ажлын нээлт, Олон улсын ядуурлын эсрэг өдөр, Таны үгийг сонсъё гэх мэт кампанит ажлуудад оролцсон.

Н.Өлзийбаяр



МУИС-ийн ОУХС-ийн 3-р дамжааны оюутан. 2007 онд Монголын Эмнести Интернэшнл элсэн, Эмэгтэйчүүдийн эрх, ЭЗНСЭ, Хүнийг хүндэл кампанит ажилд сайн дурын ажилтны гэрээ байгуулан ажилласан. 2009 онд Эмэгтэйчүүдийн эрхийн кампанит ажил, Хүнийг хүндэл, Эрх чөлөөний парад, Таны үгийг сонсъё түүх цуглуулах аянд оролцож өөрийн цагийг хүний эрхийн үйлсэд зориулжээ.

Б.Цолмон



Эрх зүйч мэргэжилтэй. 2009 оноос сайн дурын ажилнаар ажиллаж эхэлсэн бөгөөд "Эрх чөлөө Парад"-ын хөтөлбөр хариуцсан зохицуулагч, "Таны үгийг сонсъё" аян, Шинэгишүүдийн сургалт, "Хүний эрх" номын санг каталогжуулах, "Хүнийг Хүндэл" кампанит ажил, ЕБС болон их, дээд сургуулиудаар Эмнести Интернэшнлийг танилцуулах, орчуулга хийх, захидал уриалгад гарын үсэг зуруулах гэх зэрэг ажлуудад оролцсон байна.

М.Буянхишиг



ШУТИС-ийн 4-р курсын оюутан. Монголын Эмнести Интернэшнл байгууллагад 2006 оноос сайн дураар ажиллаж байна. 2009 онд "Гуантанамо Бэй – г хаах 100 өдрийн аян"-г зохион байгуулсан. Цагдаагийн Академи дээр болсон "Терроризмтэй шударгаар тэмцье" сургалт, "Эрхээ эдэлж чадвал шоколад шиг амтагдана" өдөрлөг, "Эрх чөлөөний парад"-д "Хүнийг Хүндэл" кампанит ажилд оролцсон.

Т.Төртготх



МУИС-ийн 4 дүгээр курст сурдаг. 2006 онд Монголын Эмнести Интернэшнл элссэн. 2009 онд "Таны Үгийн Сонсъё", "Хүний Эрхийн Парад", Цаазын Тавсан үзэсгэлэн, "Хүнийг Хүндэл" кампанит ажлын нээлт, Хүний Эрхийн Бингоны загвар гаргасан. "Эрхээ эдэлж чадвал шоколад шиг амтагдана"

өдөрлөгт идэвхитэй оролцсон. Ази Номхон Далайн Бүсийн Залуучуудын Сүлжээний лого зохиох уралдаанд түрүүлсэн.

Э.Хатантуул



МУИС-ОУХС-ийн 3 дугаар курсын оюутан. МЭИ-д 2008 онд элссэн. 2009 онд "Хүнийг Хүндэл", Цаазаар авах ялын эсрэг кампанит ажилд оролцсон. Хүний эрхийн боловсролын хүрээнд Найрамдал зусланд ХЭТТ тухай сургалт зохион явуулсан. Олон улсын оюутны эрхийн өдөр, ядуурлын эсрэг өдөр, олон улсын хүний эрхийн өдрүүдээр мөн Эрх чөлөөний парад, Хүнийг хүндэл кампанит ажлын хүрээнд ажилласан байна.

Х.Минжин



МУИС-ийн ЭЗС-ийн 2 дугаар курсийн оюутан. Монголын Эмнести Интернэшнлд 2009 онд элссэн. 2009 оны 3 сард олон улсын эмэгтэйчүүдийн өдөрт зориулсан арга хэмжээ, Эмнестигийн бүх гишүүдийн уулзалт, Монголын сайн дурын байгууллагынхны талбай дээрх үйл ажиллагаа Эрхийнхээ төлөө гарaa өргөцгөө хүний эрхийн парадын ажилд оролцсон ба Wire сэтгүүлийн орчуулгын багт ажилладаг.

М.Адьяням.



Барилгын коллежийн 3-р курсийн оюутан. 2004 онд элссэн. 2009 оны 2 сарын бүх гишүүдийн уулзалтыг зохион байгуулагч, Оюутны бүлгийн үйл ажиллагаа, "Эрх чөлөө" парадын сурталчилгаа хариуцсан зохицуулагч, Ядуурлын эсрэг олон улсын өдөр, Хүнийг хүндэл кампанит ажлын нээлтэнд хөтлөгч, Эмнести Интернэшнлийг төлөөлж Монголын анхны хүний эрхийн театрт "Цэнхэр ороолт" жүжигт тоглох зэргээр хүний эрхийн үйлсэд цагаа зориулж байна.

Т.Ариунтуяа.



ХУИС-ийн 4-р курсийн оюутан. Монголын Эмнести Интернэшнлд 2008 онд элссэн. Цаазаар авах ялын эсрэг өдөрлөг, Эрх чөлөөний парад, Хүнийг Хүндэл кампанит ажлын Таны үгийг сонсьё аян, Ерөнхий чуулганы ажилд туслаж, цаг заваа зориулжээ. Мөн Эмнести Интернэшнлийг төлөөлж Монголын анхны хүний эрхийн театрт тавигдсан "Цэнхэр ороолт" жүжигт дүр бүтээн оролцсон.

3.Балдорж



Монголын Эмнести Интернэшнлийн үйл ажиллагаанд олон жил идэвхитэй оролцсон гишүүдийн нэг юм. Тэрээр Хүнийг хүндэл кампанит ажил, Эрх чөлөө Парад гэх мэт үйл ажиллагаануудад оролцсон байна. Эмности Интернэшнлийнкампанитажлуудын үеэр видео бичлэг хийх, зохион байгуулалтын ажлуудад идэвхтэй оролцдог.

Т.Мөнхчимэг



"Их засаг их сургууль"-ийн 4-р курсын оюутан. 2007 онд Монголын Эмности Интернэшнэлд гишүүнээр элссэн. Цагдаагийн академид сургалт явуулан, сан арвижуулах, Эрүү шүүлтийн хохирогсод туслах олон улсын өдөр, Хүнийг хүндэл , Таны үгийг сонсьё" ажлын хүрээнд түүх цуглуулах, "Эрхээ эдэлбэл шоколад шиг амтагдана" өдөрлөг, "Эрх чөлөөний парад" Эрүү шүүл болон цаазаар авах ялын эсрэг кампанит ажил, Олон улсын оюутны эрхийн өдрөөр идэвхитэй ажилласан.

Б.Номин



"Ач" анагаах ухааны сургуулийн 1 дүгээр курсийн оюутан. Монголын Эмности Интернэшнлийгтанилцуулах өдөрлөг, сан арвижуулах үйл ажиллагаанд оролцож "Сарнайн өдөр" болон эрүүдэн шүүхийн хохирогчдод туслах өдруүд, Бирм, эрүү шүүлтгүй Монгол улсын төлөө гарын үсэг зуруулах, мөн цаазаар авах ялын эсрэг зургийн үзэсгэлэн, хүний эрхийн парадад "Хүнийг хүндэл" багт ажилласан.

А.Түвшинтуулга



Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан. Монголын Эмности Интернэшнлд 2004 онд элссэн. Төрөлжсөн эрүүгийн хуулийн үндсэн төсөлд санаалаа өгсөн. Цаазаар авах ялыг халах дэлхий нийтийн өдрөөр уран зургийн галлерейд зохион байгуулагдсан үзэсгэлэнг дэмжиж ажилласан. Хүүхдийг цаазаар авахыг таслан зогсоо ѿриан дор залуучуудын бүлгээс зохион байгуулсан уулзалтад оролцсон. Монголын Эмности Интернэшнлийн ажлын байран дахь бэлгийн дарамт, холбогдсон асуудлыг шийдвэрлэх ажлын хэсэгт орж ажилласан. Эмности Интернэшнлд сайн дураар өөрийн үнэт цаг хөдөлмөрөө хандивлаж байдаг идэвхтэй гишүүн юм.

Н.Ганчимэг



МУИС-ийн ХЭС-ийн 5 дугаар курсийн оюутан. Монголын Эмнести Интернэшнлийн хүний эрхийн сургагч багшаар бэлтгэгдсэн. Эрх чөлөөний парадыг зохион байгуулагчаар ажилласан. Цаазаар авах ялын эсрэг кампанит ажилд идэвхтэй оролцож, энэ сэдвээр олон нийтэд илтгэл тавьсан. Мессеж марафонд оролцсон. Их сургуулийн 1 дүгээр курсын оюутнуудад хэлэлцүүлэг зохион байгуулсан.

Жеймс Адамс



Жеймс Австралийн "Залуучуудын Хөгжлийн хөтөлбөрийн Элч" хөтөлбөрийн сайн дурын ажилтан. Тэрээр залуучуудын хөтөлбөрийн менежмент төлөвлөлтийн хөгжүүлэх хүрээнд тэдний манлайлах ур чадварыг дээшлүүлэх мөн хүний эрхийн үйлсэд үүрэг оролцоог нь дээшлүүлэх зорилготойгоор энд ажиллаж байна. Монголд байх хугацаандaa "Манлайллагч бэлтгэх хөтөлбөр"-т завгүй ажиллаж бас залуучуудын стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд залуу гишүүдэд туслаж ажиллаж байсан. Залуучууд болон оффисын ажилтануудтай хамт ажиллаж байхдаа маш их завгүй байж, их зүйл суралцаж, олон олон гайхалтай дурсамжтай буцах гэж байгаадаа сэтгэл хангалуун байна.

Кристина Жосс



Надад Монголын Эмнести Интернэшнл хамт олонгийн ажиллахад маш их сэтгэл хангалуун байна. Би эндээс сайн дурынхан болон ажилтнуудаас энэ төрлийн байгууллагуудад ховорхон узэгдэх урам зориг, өөрийгөө зориулж байгаа сэтгэлийг харж байлаа. Монголын Эмнести Интернэшнлийн өмнө Эмнестигийн зорилго, даалгавартай холбогдсон нөр их ажил болон тэдний дэмждэг, өмнө нь тулгамдсан маш их ажил байдаг. Гэсэн хэдий ч тэдний тэмүүлэл, шийдэмгийн байдал бусдад нөлөөлдөг. Би тэднийг амжилтанд хүрнэ гэдэгт, өөрчлөлт хийж, олон нийтийн санаа бодолд хүрч зорилгодоо хүрнэ гэдэгт итгэлтэй байна. Миний сургалтан дээрээ зөвлөсөн санаануудыг хэрэгжүүлж улам их мөнгө санхүү сайн дурынханы дэмжлэгийг авч чадна гэдэгт итгэлтэй байгаа. Тэд зорьсон бүхнээ маш сайн хийж чадна гэж найдаж байна.

Дадлагын оюутан

Монголын Эмнести Интернэшнл Байгууллагад Монгол Улсын Их, Дээд сургуулиудын төгсөхөнгийн оюутнууд мэргэжлийн дадлага ажлыг хийдэг. Тэд байгууллагын зорилго үйл ажиллагаатай танилцах, зохион байгуулж буй үйл ажиллагаануудад хамтран оролцох мөн кампанит ажлуудыг зохион явуулахад идэвхитэй оролцдог

Б.Мөнхтуяа



Б.Мөнхтуяа МУИС-ийн ОУХС-ийн ОУЭЗХ-ны IV ангид сурдаг. Сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан мэргэжлийн дадлагын ажлаа Монголын Эмнести Интернэшнлд 2009 онд хийсэн. Дадлагын хугацаанд орчуулгын ажил хийсэн. Мөн Эмнести Интернэшнлийн "Бүх гишүүдийн уулзалт"-нд оролцож хүний эрхтэй холбоотой өдрүүдээр зохиогддог арга хэмжээнүүдэд оролцож, гишүүн болсон байна.

Б.Ган-Эрдэнэ



МУИС-ийн ОУХС-ийн 4-р дамжааны оюутан Б.Ган-Эрдэнэ нь 2009 онд мэргэжлийн дадлагын ажлыг хийж гүйцэтгэсэн. Дээрх хугацаанд "Эрх чөлөөний парад", "Хүнийг Хүндэл", "Цаазаар авах ялыг халъя" зэрэг кампанит ажлуудад оролцож, Бүлгийн чадавх бэхжүүлэх сургалтыг зохион байгуулсан. Дадлагын хугацаандаа сайн дурын ажилтны гэрээг байгуулж үргэлжлүүлэн ажиллаж байна.

ГАРЧИГ

КАМПАНИТ АЖИЛ.....	10
1. Цаазаар авах ялын эсрэг.....	10
● Дэлхий нийтийн чиг хандлага	
● Нөлөөллийн ажил	
● Эмнести Интернэшнлийн зөвлөмжийн хураангуй	
● Яаралтай үйл ажиллагаа	
● “Цаазын тавцан дээр” зургийн үзэсгэлэн	
● Сургалт	
2. Эрүүдэн шүүхийн эсрэг.....	13
● 100 өдрийн сануулга	
● Цагдаагийн Академи	
● Нөлөөллийн ажил	
● Эрүүдэн шүүхийн эсрэг Конвенцийн Нэмэлт Протокол	
● “Хоригдогсдын хүн гэсэн нэр төрийг нь хүндэтгэн харьцах ёстой” гарын авлага	
● Эрүү шүүлтийн хохирогчдод туслах олон улсын өдөр	
● Эрүү шүүлтгүй Монгол улсын төлөө	
● Хорих ангийн албан хаагчид болон нийгмийн ажилтнуудад сургалт	
● Хэвлэл мэдээлэл	
3. Хүнийг хүндэл.....	18
● Сургалт	
● “Таны үгийг сонсьё” аян	
● Ази Номхон Далайн Бүсийн Залуучуудын Элч	
● Ядуурлыг эсрэг олон улсын өдөр	
● Нөлөөллийн ажил	
4. “Эмэгтэйчүүдийг хүчирхийлэхийн эсрэг” кампанит ажил.....	21
● Сургалт	
● Кино хэлэлцүүлэг	
● Сарнайн өдөр	
● “Ве” өдөрлөг	
● Нөлөөллийн ажил	
5. Улс орнуудын төлөөх кампанит ажил.....	23
● Цагаач ажилтан	
● Олон улсын хамтын ажиллагаа	
● Хүний эрхийн хамгаалагчид	
● Захидал уриалгын марафон	
● Эмнести Интернэшнлийн судлаачдын айлчлал	

ХҮНИЙ ЭРХИЙН БОЛОВСРОЛ.....26

- Хүний эрхэд ээлтэй сургууль
- Хүний эрхийн сургагч багш
- Хамтын ажиллагаа
- Урилгаар зохион байгуулсан сургалт
- Хүний эрхийн боловсролын “Белинда” тэтгэлэг
- Хүний эрхийн боловсролын стратеги төлөвлөгөөний үнэлгээ

ЗАЛУУЧУУД.....31

- Сургалт
- Сайн дурынхан
- Цэмцгэр Монгол наадам
- Үйл ажиллагааны үнэлгээ
- Эрх чөлөөний парад
- Хамтын ажиллагаа
- Төлөвлөлт, шийдвэр гаргах болон хариуцлага

БАЙГУУЛЛАГЫН ӨСӨЛТ ХӨГЖИЛТ.....33

- Гишүүнчлэл, бүлгийн байдал
- Гишүүдийн улирлын уулзалт
- Гишүүдэд зориулсан сургалт
- Бүлгийн уулзалт, үйл ажиллагаа
- Орон нутаг дахь бүлгийн үйл ажиллагаа
- Сан арвижуулалт
- Төлөвлөлт, шийдвэр гаргалт, хариуцлага
- “Хүний эрхийн боловсрол номын сан”
- Оролцсон улсын хурал семинар
- Монголын Эмнэсти Интернэшнлийн үүсгэн байгуулсагдсаны 15 жилийн ой

ХЭВЛЭСЭН МАТЕРИАЛ.....39

- Цахим хуудас
- The Wire сонин бичиг
- Аюулгүй орчин охидын эрх
- Шаардлагад нийцсэн орон байртай байх эрх
- Цагаач ажилтны эрх
- АСЕАН-ны Тунхаг ба Хүний Эрх
- Боломж нээв үү эсвэл нүд хуурав үү?
- Хүнийг хүндэл
- Өөрчлөгдж буй ертөнц дэх хүний эрхийг хамгаалах нь
- Хүний эрх сургалтын Хөтөлбөрт: Математик, Түүх
- Орчин үеийн боолчлол ба хүний наймаа
- Эрхээ эдэлцгээ: Жендэрийн тухай мэдлэгийг дээшлүүлэх сургалтын гарын авлага
- Эмэгтэй хүний эрхийн хамгаалагчид
- “Би эндээс хаачих вэ?”
Монгол Улсад болсон 2008 оны 7-р сарын 1-ний үйл явдлын сургамж

САНХҮҮГИЙН ТАЙЛАН.....42

- 2009 оны санхүүгийн
- 2008 оны санхүүгийн тайлан хөндлөнгийн аудитын тайлан

ЦААЗААР АВАХ ЯЛЫГ ХАЛАХ КАМПАНИТ АЖИЛ

Монголын Эмнести Интернэшнл байгууллагаас энэ кампанит ажлын хүрээнд цаазаар авах ялыг халахыг дэмжигчдийн хүрээг тэлэх, олон нийтийг гэгээрүүлэх, Монгол улсын Эрүүгийн хууль дахь цаазаар авах ял оноо зүйл заалтыг цөөрүүлэхэд нөлөөлөх, гүйцэтгэлийг тойрсон нууцлалтай холбоотой асуудалд анхаарал хандуулах, цаазаар авах ялыг дэлхий нийтээр халахад олон улсын хамтын ажиллагааг бэхжүүлэх зорилго тавин ажиллалаа.

Дэлхий нийтийн чиг хандлага

Дэлхий даяар цаазаар авах ялыг халах цаг иржээ. Жил ирэх бүр цаазаар авах ялыг халж байгаа улс орнууд нэмэгдсээр байна. Цаазаар авах ялын гүйцэтгэл харгислалыг төрүүлж байгааг туршлага харуулдаг. Цаазаар авах ял нь улс төрийн хүчирхийлэл, гэмт хэргийг бууруулахад онцгой хүчтэй нөлөө үзүүлдэг гэдэг нь хаана ч нотлогдсонгүй. Улс орон бүрт энэ ял арьсны өнгөөр алагчлах буюу ядуус, үндэсний цөөнхийн эсрэг харилцан адилгүй хэрэглэгдсээр байна. Мөн улс төрийн хэмлэгдүүлэлтийн зэвсэг болсоор иржээ. Энэ ялыг дур зоргоор ногдуулж, гэм зэмгүй хүмүүсийг шийтгэсэн тохиолдолд эргүүлэн буцаах боломжгүй бөгөөд хүний үндсэн эрхийг зөрчиж байгаа юм.

Цаазаар авах ял нь буцааж болшгүй эрсдэлтэй алдаагдагуулаад зогсохгүй энэ нь онцгой урьдчилан сэргийлэх, хамгаалах үр нөлөөтэй нь батлагдахгүй байна. Энэ үйлдэл нь засран хүмүүжих боломжийг хааж, шийдлийг эрж хайхаас илүүгээр хүний цогц асуудалд амар хялбараар хариу өгч байгаа хэрэг юм. Энэ нь хүчирхийллийн шинж тэмдэг болохоос шийдэл биш, хүний нэр төрийг гутаан доромжилсон хэрэг мөн.

Өнөөдөр дэлхийн улс орны гуравны хоёр нь буюу 138 орон цаазаар авах ялыг хуулиндаа болон практикт халаад байна. Үүнээс 92 орон цаазаар авах ялыг бүрэн халж, 10 орон зөвхөн онцгой тохиолдолд хэрэглэхээр зааж, 36 орон практикт халж сүүлийн 10 гаруй жил ялын гүйцэтгэл хэрэгжүүлэгүй байна. Үлдсэн Хятад, Иран, АНУ зэрэг 60 орон цаазаар авах ялыг хэрэглэсээр байгаа боловч тэдгээрийн зарим нэг оронд ял оноо хэргийн тоо буурчээ.

Хууль бусаар, дур мэдэн буюу олноор нь цаазаар авах асуудлаарх НҮБ-ын Тусгай илтгэгч “цаазаар авах ялыг хэрэглэж байгаа хаана ч ил тод байх нь маш чухал юм. Гүйцэтгэсэн талаар нууцлах нь хүний эрхийн хэм хэмжээг зөрчиж байгаа хэрэг

мөн. Цаазаар авах ялын гүйцэтгэлийн талаар бүрэн дүүрэн үнэн зөв мэдээллийг нийтлэх, наад зах нь жил бүрийн тайлан мэдээнд нэгтгэсэн хувилбарыг нийтэлж байх ёстой” хэмээн мэдэгдсэн.

Эмности Интернэшнл байгууллагаас цаазаар авах ялын талаар эмхтгэн гаргадаг “Цаазаар авах ял ба гүйцэтгэл 2008”, “Цаазаар авах ялыг халсан ба хэрэгдэж байгаа орнуудын жагсаалт”, “Цаазаар авах ялыг халах тухай олон улсын гэрээ хэллэлцээрийг баталсан байдал” баримт бичгүүдийг орчуулан хэвлэж тараалаа.

Нөлөөллийн ажил

Эрүүгийн (төрөлжсөн) хуулийн төсөлд хүргүүлэх санал, зөвлөмж

ҮИХ-ын гишүүн Сайхансамбуугийн санаачилсан “Эрүүгийн (төрөлжсөн) хуулийн төсөлд санал боловсруулах ажилд бүх бүлгүүдийн төлөөлөл оролцсон ажлын хэсэг байгуулж, Оюутан залуучууд, Чөлөөт, Үйлдвэрчний эвлэл, Хуульчдын бүлгийн гишүүд нар манлайлан идэвхтэй оролцлоо.

Эмнести Интернэшнлийн Олон Улсын Төвийн Хуульчдын баг Монголын Эмности Интернэшнлийн хуульчдын бүлгийн гишүүдтэй хамтран Эрүүгийн хуулийн төсөлд судалгаа шинжилгээ хийн санал зөвлөмж боловсруулан хүргүүлэв. Эрүүгийн хуулийн төсөлд цаазаар авах ял оноож буй зүйл заалтыг цөөрүүлсэн, хууль шүүхийн өмнө хүн бүр тэгш эрхтэй байх зарчмыг баталгаажуулсан зэрэг сайшаалтай талууд байгаа хэдий ч эрүүдэн шүүх гэмт хэргийг конвенцид зааснаас явцуу хүрээнд тодорхойлох зэрэг дутагдал доголдол байгааг хууль тогтоогчид анхааран үзэж, тус хуулийг батлагдахаас өмнө түүний алдаа, дутагдлыг засаж, сайжруулахын тулд тодорхой нэмэлт, өөрчлөлтүүдийг хийх шаардлагатай болохыг тодорхойлон санал зөвлөмжийг хүргүүллээ.



ЭМНЕСТИ ИНТЕРНЭШНИЙ ЗӨВЛӨМЖИЙН ХУРААНГУЙ

Эмнести Интернэшнл нь хуулийн төсөлд нэмэлт өөрчлөлт оруулахыг хууль тогтоогч нарт уриалж байна:

- Монгол Улс дахь цаазаар авах ялыг бүхэлд нь халах.
- Олон улсын эрх зүйн дагуу бүх гэмт хэргүүдийг үндэсний шүүхээр хянан шийдвэрлэх явдлыг баталгаажуулах, ялангуяа: төрлөөр устгах, хүн төрөлхтний эсрэг, дайны, эрүүдэн шүүх, хууль бусаар ял гүйцэтгэх, хүчээр сураггүй алга болгох гэмт хэргүүдэд.
- Төрлөөр устгах, хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг, дайны, эрүүдэн шүүх, хууль бусаар ял гүйцэтгэх, хүчээр сураггүй алга болгох гэмт хэргүүдэд сэжиглэгдсэн аливаа этгээдийн хувьд үйлчлэх түгээмэл харьяаллыг Монгол Улсын шүүх хэрэгжүүлэх эрх хэмжээг олгож, 12 дугаар зүйлийн хүрээг өргөтгөх.
- Гэмт хэрэг хээээ үйлдэгдсэнээс үл хамааран төрлөөр устгах, хүн төрөлхтний эсрэг, дайны, эрүүдэн шүүх, хууль бусаар ял гүйцэтгэх, хүчээр сураггүй алга болгох гэмт хэргүүдийг Монгол Улсын шүүх хянан шийдвэрлэх харьяалал байгаа гэдгийг баталгаажуулах,
- Удирдагч, захирагчийн хариуцлагын талаар тодорхой заалтууд нэмэх.
- Төрлөөр устгах, хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг, дайны, эрүүдэн шүүх, хууль бусаар ял гүйцэтгэх, хүчээр сураггүй алга болгох гэмт хэргүүдийг үйлдсэн нь даргын тушаал байсан ч гүйцэтгэгчийг гэм буруугаас чөлөөлж чадахгүй гэдгийг тусгах.
- Төрлөөр устгах, хүн төрөлхтний эсрэг, дайны, эрүүдэн шүүх, хууль бусаар ял гүйцэтгэх, хүчээр сураггүй алга болгох гэмт хэргүүдэд хөөн хэлэлцэх хугацааг тогтоохгүй байх.

Яаралтай үйл ажиллагаа

Texas нь АНУ-д цаазаар авах ялыг хамгийн их хэрэглэдэг муж болоод байна. 1977 оноос АНУ цаазаар авах ялыг сэргээн хэрэглэж ирснээс хойш 1175 хүнийг цаазаар авсны 441-ийг нь Texas муж гүйцэтгэсэн байна. Энэ жилийн тухайд 39 цаазаар авах ялыг гүйцэтгээд байгаа бөгөөд үүний 18-ыг нь Texas мужид гүйцэтгэжээ.

Эмнести Интернэшнлийн олон улсын төвөөс цаазаар авах ял болон бусад хүний эрхийн зөрчлүүдэд өртсөн хувь хүмүүсийг хамгаалхын төлөө байнга яаралтай үйл ажиллагаа өрнүүлдэг. 9 сард болсон Texas мужид цаазаар авах ял сонсоод 12 жил болсон цаазаар авах ялд өршөөл үзүүлэхийг хүссэн захидал уриалгыг илгээх Яаралтай үйл

ажиллагаанд Чөлөөт бүлгийн гишүүд идэвхтэй оролцож, МУИС-ийн ОУХС-ийн оюутнуудын гарын үсгийг цуглуулж илгээлээ.

Манай гишүүд дэмжигчдийн оролцсон яаралтай үйл ажиллагаа үр дүнгээ өгч АНУ-ын Дээд шүүхээс Кеннеф Мослэйн хэргийг авч хэлэлцэхээ хойшлуулсан байна.

Ө Эмнести Интернэшнл байгууллагын Зүүн Азиийн Хөтөлбөрийн дэд дарга Розеан П.Райф, тус хөтөлбөрийн кампанит ажлын зохицуулагч Кэтрин Беракло нар энэ оны 7 дугаар сард Монгол улсад хийсэн хүний эрхийн нөхцөл байдалтай танилцах айлчлал хийллээ. Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржтой хийсэн албан ёсны уулзалтын үеэр Монгол улс дахь цаазаар авах ялыг тойрсон асуудлыг хөндөн ярилцахад ерөнхийлөгч Монгол улс дахь хүний амьд явах эрхийг хангах, цаазаар авах ялыг цаашид халах асуудлаа ажиллахаа мэдэгдсэн байна.

Айлчлалын үр нөлөөгөөр Монгол улс дахь цаазаар авах ялтай хэрэг дээр яаралтай үйл ажиллагааг олон улсад өрнүүлснээр Ерөнхийлөгч цаазаар авах ялтай хоригдлуудын ялд учлал үзүүлсэн байна.



Цаазаар авах ялын эсрэг Дэлхий нийтийн өдөр “Цаазын тавцан дээр” зургийн үзэсгэлэн

Хүний Эрхийн Үндэсний Комисстой хамтран 2009 оны 10-р сарын 9-10-ны өдрүүдэд “Цаазын тавцан дээр” зургийн үзэсгэлэнг Монголын Үндэсний Орчин үеийн Уран зургийн галерейд зохион байгууллаа.



Үзэсгэлэнд Нигерийн Инуугу шоронд есөн жил хоригдож байхдаа үй олноор нь буудан хороо болон дүүжлэх ялын гүйцэтгэлийн гэрч болж байсан Артур Жуда Энжелийн зурсан зургууд тавигдлаа. Тэрээр цаазаар авах ял шийтгэл нь хэрцгий, хүнлэг бус, хүний нэр төрийг хэрхэн гутаан доромжилж байгааг өөрийн хамт хоригдож байсан цаазаар авахуулах ялтай хоригдлуудын дүр зургаар өгүүлжээ.

Үзэсгэлэнгийн нээлтэнд Их Британи, Франц улсаас Монгол улсад суугаа элчин сайдууд, ерөнхийлөгчийн хүний эрх, иргэний оролцооны бодлогын зөвлөх, хууль зүйн сургуулийн багш, оюутнууд, шүүгчид, прокурорууд, иргэний нийгмийн байгууллагын төлөөлөгчид, Монголын хэмлэгдэгсийн холбооны төлөөлөгчид, хувь хүмүүс оролцлоо.

Монголын Эмнести Интернэшнлийн удирдах зөвлөлийндарга Р.Янжмаа үзэсгэлэнгнээж, цаазаар авах ялыг халах дэлхий нийтийн чиг хандлага, Эмнести Интернэшнлийн үзэл баримтлал болон “Цаазын тавцан дээр” зургийн үзэсгэлэнгийн тухай танилцууллаа. Мөн Хүний Эрхийн Үндэсний Комиссын гишүүн Ж.Дашдорж “Цаазаар авах ялын талаар Хүний эрхийн үндэсний комиссын баримталж буй бодлого” сэдвээр илтгэл тавилаа.

Нээлтийн үеэр хэдийгээр цөөн тооны хүмүүс цаазаар авах ял байх нь зүйтэй хэмээн үзэл бодлоо илэрхийлж байсан ч, цаазаар авах ялаас татгалзахыг дэмжиж байгаагаа илэрхийлж яруу найрагч, иргэд уг хэлж, Их Британийн элчин сайд Уильям Диксон монголчуудад хандан амьд явах эрхийг зөрчиж байгаа цаазын ялаас татгалзахыг уриалж, Ерөнхийлөгчийн хүний эрх, иргэний оролцооны бодлогын зөвлөх Ц.Оюунгэрэл Монгол улс цаазын ялаас татгалзах талаар цаашид ажиллах болно хэмээн мэдэгдлээ.

2 өдөр үргэлжилсэн уг үзэсгэлэнг 1000 орчим хүн үзэж сонирхсон байна. Мөн TV9, Ийгл, Шинэ Монгол телевизүүд үзэсгэлэнгийн талаар сурвалжилсан мэдээ мэдээллийг олон нийтэд хүргэж, Ийгл телевиз зочны цагаараа Монголын Эмнести Интернэшнлийн гүйцэтгэх захирлыг урьж оролцуулан цаазаар авах ялыг халах тухай дэлхий нийтийн чиг хандлага, Эмнести Интернэшнлийн үзэл баримтлал, Монгол улс дахь цаазаар авах ялын талаар ярилцлаа. Мөн өдрийн сонин, зууны мэдээ, нийгмийн толь, ардчилал зэрэг сонин хэвлэлүүд цаазаар авах ял, “Цаазын тавцан дээр” үзэсгэлэнгийн тухай мэдээ мэдээлэл нийтлэлийг хэвлэн нийтллээ.

12

“Цаазаар авах ялын тухай” сургалт

Шихихутуг хууль зүйн сургуулийн оюутнуудын дунд “Хүний эрх ба цаазаар авах ял” сэдэвт хэлэлцүүлгийг Хүний Эрхийн Үндэсний Комисстой хамтран явуулав. Хэлэлцүүлэгт тус сургуулийн 100 орчим оюутнууд оролцож цаазаар авах ялын

талаарх үзэл бодлоо чөлөөтэй хуваалцан ярилцаж байлаа.


МУИС-ийн философиин тэнхимиийн багш Эмэгтэйчүүдийн бүлгийн гишүүн Б.Мөнхжавхлан ЭМШУИС, МУИС-ын ЭЗС, ОҮХС-ийн нийт 500 орчим оюутнуудад философиин хичээлээр “Цаазаар авах ялыг халах чиг хандлага” сэдвээр семинар явуулж, хэлэлцүүлэг өрнүүлэв. Цөөнгүй тооны оюутнууд хэлэлцүүлгийн төгсгөлд цаазаар авах ялыг халах нь зүйтэй гэсэн чиг хандлагад хүрч чадсан нь семинарын үр дүн оршиж байлаа.

Мөн МУИС-ийн Эдийн засгийн I дамжааны оюутнуудад залуучуудын бүлгийн гишүүн Н.Ганчимэг цаазаар авах ялыг тухай Эмнести Интернэшнлийн чиг хандлага сэдвээр илтгэл тавьж хэлэлцүүлэг өрнүүлэв.



ЭРҮҮДЭН ШҮҮХИЙН ЭСРЭГ КАМПАНИТ АЖИЛ

Монгол улсад Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгийй, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцах шийтгэхийн эсрэг конвенцийн хэрэгжилтийг хангахад нөлөөлөл үзүүлэх, түүний Нэмэлт Протоколд нэгдэн орохыг Монгол Улсын Засгийн Газарт уриалах, эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Үндэсний механизмийг бий болгоход чиглэгдсэн үйл ажиллагааг авч хэрэгжүүлэх: ТББ-уудыг хорих газарт хараат бус мониторинг хийхэд чадавхжуулах, дадлагажуулах, хөдөлгөөний хүрээнд “терроризмийн эсрэг дайн” нэрийн дор эрүүдэн шүүх, зүй бусаар харьцах явдалтай тэмцэх зорилт тавин ажиллалаа.



100 ӨДРИЙН САНУУЛГА

Эмнести Интернэшнл нь Гуантанамог хаахыг шаардсан хамгийн анхны байгууллагуудын нэг юм. АНУ Гуантанамо Бэй дэх хорих газарт хүмүүсийг шилжүүлэн хорьж эхэлснээс хойш 7 жил өнгөрчээ.

Эмнести Интернэшнл байгууллагаас шинээр сонгогдсон АНУ-ын Ерөнхийлөгч Барак Обамагаас хандан ажлын эхний 100 өдөртөө багтаж, Гуантанамо Бэй дэх хорих газрыг хаах тухай нарийвчилсан төлөвлөгөөг олон нийтэд зарлах, олон улсын эрх зүйн хүрээнд эрүү шүүлт, зүй бус харьцааг хориглох тухай Ерөнхийлөгчийн зарлиг гаргах, АНУ-ын засгийн газраас “терроризмийн эсрэг дайн” нэрийн дор хэрэгжүүлсэн хүний эрхийн зөрчлүүдэд хараат бус хөндлөнгийн шалгалт явуулахыг баталгаажуулан хүний эрхийн асуудлаар бодит шинэчлэлт өөрчлөлт хийхийг шаардсан “100 өдрийн сануулга”-ыг хургуулсан байна. Үүнд:

- Гуантанамо Бэй дэх хорих газрыг хааж, хууль бусаар баривчлах, хорих явдлыг төгсгөл болгох
- Эрүү шүүлт, зүй бус харьцааг таслан зогсоох
- Эрүүдэн шүүгчид, хүний эрхийн зөрчил үйлдэгчид ял шийтгэлгүй өнгөрөх явдлыг эцэс төгсгөл болгохыг шаардлаа.

Терроризмтэй шударгаар тэмцье үйл ажиллагааны хүрээнд Монголын Эмнести Интернэшнл байгууллагын гишүүд дэмжигчид олон нийтийн санаа бодлыг нэмэгдүүлэх, нөлөөллийн дараах үйл ажиллагааг зохион байгууллаа.

Бүх гишүүдийн уулзалтаар



Оюутны бүлгийн гишүүд 2-р сард болсон бүх гишүүдийн уулзалтаар терроризмтэй тэмцэх нь кампанит ажлын хүрээнд хэрэгжүүлж байгаа “Ерөнхийлөгч Барак Обамад хандсан 100 өдрийн сануулга”-ын цахим ажиллагаа, орчуулан бэлтгэсэн гарын авлага материалыг танилцуулан, тарааж, тус цахим хуудсаар зочлон гарын үсгээ зурж дэмжихийг уриаллаа. Мөн Гуантанамогийн хоригдлуудыг илэрхийлсэн хувцас дээр гарын үсэг зуруулж, гишүүдийг идэвхжүүлэв. Мөн шинэ гишүүдийн сургалтаар дээрх үйл ажиллагааг танилцуулж, гарын үсэг цуглуулав.



Цагдаагийн Академи

3-р сарын 24-нд оюутан залуучуудын бүлгийн гишүүд Цагдаагийн Академийн оюутны зөвлөлтэй хамтран сонсогч нарыг идэвхжүүлэх зорилгоор Терроризмтэй шударгаар тэмцье кампанит ажил, хүч ба галт зэвсэг хэрэглэх нь сэдвээр тус тус илтгэл тавилаа. Энэ үеэр “АНУ-ын Ерөнхийлөгч Барак Обамад хандсан 100 өдрийн сануулга”-ын цахим ажиллагааны танилцуулгыг хийж, цахим

өргөх бичигт гарын үсэг зурахыг уриалав. Мөн Гуантанамогийн хоригдлуудыг илэрхийлсэн улбар шар өнгийн хувцас дээр гарын үсэг зуруулав.



Нөлөөллийн ажил

● “АНУ-ын Ерөнхийлөгч Барак Обамад хандсан 100 өдрийн сануулга” цахим ажиллагааг олон нийт, гишүүдэд танилцуулах явцад Гуантанамогийн хоригдлуудын илэрхийлэл бүхий улбар шар өнгийн хувцас дээр 500 гаруй гарын үсэг цуглууллаа. Оюутны бүлгийн төлөөлөл, кампанит ажил, өсөлт хөгжил хариуцсан зохицуулагч нар гарын үсэг бүхий тэдгээр хувцасыг Гуантанамо Бэй дэх хорих газрыг хааж, хууль бусаар баривчлах, хорих явдлыг төгсгөл болгох, эрүү шүүлт, зүй бус харьцааг таслан зогсоох, ял шийтгэлгүй өнгөрөх явдлыг эцэс төгсгөл болгохыг уриалсан Эмнестигийн мессэжийн хамт Монгол улсад суугаа АНУ-ын элчин сайдын яаманд гардуулан өгөв. Уулзалтын үеэр АНУ-ын ЭСЯ-ны улс төрийн албаны дарга Эндрю К.Ковингтон бидний хүргүүлсэн хувцасыг АНУ-ын засгийн газарт хүргүүлж, бидний хүсэлтийг дамжуулан хэлэхээ амласан. Монголын Эмнести Интернэшнл нь олон нийтэд харагдахуйц үйл ажиллагаа явуулдагаараа бусад төрийн бус байгууллагуудаас онцлог байдал тухай сэтгэгдлээ хуваалцсан юм.

● “Сэжигтэн яллагдагчийн цагдан хорих ажиллагаанд анхаарах зарим асуудлууд” сэдвээр онол практикийн бага хуралд “Эрүүдэн шүүхийн эсрэг Конвенцийн Нэмэлт Протоколд нэгдэн орохын ач холбогдол” сэдвээр илтгэл тавьж оролцлоо.

● Тагнуулын ерөнхий газрын 150 орчим албан хаагч нарт Эрүүдэн шүүхийн эсрэг конвенциор илтгэл тавилаа.



Эрүүдэн шүүхийн эсрэг Конвенцийн Нэмэлт Протокол /ЭШЭКНП/



Монголын Эмнести Интернэшнл, Женевийн Эрүүдэн шүүхээсурьдчилан сэргийлэх нийгэмлэгээс хамтран зохион байгуулсан Монгол улс дахь хорих, цагдан хорих газарт хийх мониторингийн ажлыг дотоодын төрийн бус байгууллагудын хүний эрхийг хамгаалагчид, хуульчид, сэтгэл зүйч, судлаачид хамтран зургаан сарын хугацаанд хэрэгжүүлсэн.

Дээрх мониторингийн ажлыг тайлагнах, дүгнэх уулзалтыг ШШГЕГ-ын удирдлагууд, мониторингт хамрагдсан хорих 401, 403, 407, 411-р анги, цагдан хорих 461-р ангийн удирдлагууд, ХЭҮК, ХЭДХЯ-ны Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийн хороо, НҮБ-ын хууль зүйн хүртээмж ба эрх зүйн туслалцааны төв, мониторингийг хэрэгжүүлсэн хүүхэд, эмэгтэйчүүд, хүний эрхийн чиглэлээр ажилладаг “Хууль хүний эрх”, “Социологийн Академи”, “Хүүхэд Өсвөр үеийг ивээх төв”, “Цахим боловсрол төв, “ХЭҮТ”, “Үндэсний ногоон хөдөлгөөн” ТББ-уудын төлөөлөгчдийн дунд зохион байгуулав. Уулзалтаар хорих, цагдан хорих газруудад мониторинг хийсэн ТББ-уудын тайлангийн эмхтгэлийг танилцуулж, мониторингийн явцад илрүүлсэн дутагдал доголдол, оолот амжилт, тулгарсан бэрхшээл, дүгнэлтийн талаар харилцан ярилцав. Мониторингийн тайлангийн эмхтгэлийн дүгнэлтээс товчлон хүргэвэл:

Мониторингийн хугацаанд хамрагдсан нийт хорих, цагдан хорих газарт хоригдгосодтой харилцах харилцаа доголдолтой, хамгаалах арга хэмжээ тодорхой заалттай боловч зөрчигддөг, материаллаг нөхцөл зарим талаараа сайжирч байгаа, дэглэм ба арга хэмжээ дунд зэрэг, эрүүл мэндийн үйлчилгээ дутагдалтай, хорих байгууллагын ажилтны мэргэжлийн бэлтгэл, ажлын орчин нөхцлийг цаашид сайжруулах шаардлага байгаа нь ажиглагдаа...

/Мониторингийн багийн тайлангаас/

Мөн Монгол улсын Сэжигтэн, Яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлд хорих байрны нөхцөл байдалтай танилцахаар гадны хүмүүс орж болохыг зөвшөөрсөн ч цагдан хоригдож

байгаа хоригдолтой ганцаарчилан уулзах нь 19 дүгээр зүйлд хориотой байгаа нь НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 1990 оны 12-р сарын 14-ний өдрийн 45/111 дүгээр тогтоолоор батлагдсан "Хоригдлууттай харьцах үндсэн зарчмууд"-ын 29 дүгээр зарчимтай зөрчилдэж байна.

ТББ-ын хэрэгжүүлсэн мониторингийн тайлан дүгнэлтэнд үндэслэн тухайн хорих, цагдан хорих газар болон бусад холбогдох төр засгийн байгууллагын удирдлагуудад хандан гаргасан санал зөвлөмжийг холбогдох хүмүүст хүргүүлэв. Үүнд УИХ-ын гишүүнээс дэмжин ажиллахаа илэрхийлсэн хариу ирүүллээ.

"Хоригдогсдын хүн гэсэн нэр төрийг нь хүндэтгэн харьцах ёстой" гарын авлага

ЭШЭКНП-д нэгдэн орж, Урьдчилан Сэргийлэх Үндэsnий Механизм бий болгох нь эрүүдэн шүүж, зүй бус харьцах явдлаас урьдчилан сэргийлэх үр дүнтэй чухалалхам болохыг таниулахзорилгобуний ажлын хүрээнд авч хэрэгжүүлсэн мониторингийн явцад "Хоригдогсдын хүн гэсэн нэр төрийг нь хүндэтгэн харьцах ёстой" гарын авлагыг 1000 хувь хэвлүүлэн хорих, цагдан хорих газрын ажилтан албан хаагчдад ШШГЕГ-аар дамжуулан хүргүүлэв.

Эрх чөлөөгөө хязгаарлуулсан хүмүүсийн байгаа газарт тэгш бус харилцаа үүсэх эрсдэл өндөр бөгөөд үүнээс урьдчилан сэргийлэх зорилгоор авч хэрэгжүүлж буй арга хэмжээний нэг болох хорих байгууллагын ажилтан алба хаагч наарт зориуулан гаргасан уг гарын авлага нь хорих, цагдан хорих байгууллагад тавигддаг олон улсын болон бус нутгийн стандартыг хялбаршуулан таниулахын зэрэгцээ үндэsnий хууль тогтоомжоо эргэн харж юуг анхаарвал зохистойг санал болгосон юм.



ЭРҮҮ ШҮҮЛТИЙН ХОХИРОГЧДОД ТУСЛАХ ОЛОН УЛСЫН ӨДӨР

НҮБ-ын Ерөнхий Ассамблей эрүү шүүлтийн хохирогчдод туслах, мөн эрүү шүүлтийг таслан зогсооход анхаарал хандуулах зорилгоор 1997 оноос эхлэн жил бурийн 6 дугаар сарын 26-ныг Эрүү шүүлтийн хохирогчдод туслах олон улсын өдөр болгон тэмдэглэж байхаар шийдвэрлэсэн.

2009 оны 6 сарын 26-ны энэ өдрийг оюутан залуучууд, чөлөөт, эмэгтэйчүүдийн бүлгийн гишүүд хамтран уламжлал ёсоор Оюутны талбай дээр

тэмдэглэн өнгөрүүлэв.

Энэ өдөр Эмнести Интернэшнл байгууллагаас өрнүүлж байгаа АНУ-ын хорих лагерь Гуантанамо Бэй зэрэг хорих газруудад өргөн тархсан терроризмийн эсрэг дайн нэрийн доорх эрүү шүүлт, зүй бус харьцааг таслан зогсоох, эрүүдэн шүүгчдэд хариуцлага тооцохыг шаардах, цаашид ийм үйлдэл гаргахгүй байхад анхаарахыг шаардаж буй "Терроризмтэй шударгаар тэмцье" кампанит ажлын талаар олон нийтэд танилцуулж, захидал уриалгад 150 гаруй гарын үсэг зуруулан АНУ-ын ерөнхийлөгч Барак Обамад илгээлээ.

Мөн хорих, цагдан хорих, цагдаагийн байгууллагын удирдлагуудад хандан "Эрүүдэн шүүхийн эсрэг конвенц"-ийг хэрэгжүүлэх талаар ямар арга хэмжээ авч хэрэгжүүлж байгаагаа баталгаажуулж, олон нийтэд мэдээлэхийг шаардсан "Эрүү шүүлтгүй МОНГОЛ улсын төлөө" ил захидалыг хэвлэн гаргаж, олон нийтийн гарын үсэг цуглуулах ажиллагааг эхлүүлэв.



Иргэд олон нийтээс Монгол улсад эрүүдэн шүүх явдал байгаа эсэх талаар явуулсан тандалтын судалгаананд 180 хүн хамрагдлаа. Санал асуулгыг дүгнэхэд:

1. Та найз нөхөд, дотны хүмүүсээс төрийн албан тушаалтны зүй бус харьцаанд өртлөө гэх гомдлыг сонсож байсан уу: Тийм - 55%
2. Эрүү шүүлт тулгасан буруутай этгээдтэй Монгол улс хариуцлага тооцож чаддаг гэдэгт та итгэлтэй байна уу: Тийм- 13%, Үгүй-63%
3. Улсын Ерөнхий Прокурорын дэргэдэх Мөрдөн байцаах алба ямар үүрэгтэйг та мэдэх үү: Тийм- 40,5%, Мэдэхгүй-37%
4. Эрүү шүүлтэнд өртөж хохирсон этгээдэд таны туслалцаа хэрэгтэй гэвэл та туслахад бэлэн үү: Тийм-78%,
5. Эрүүдэн шүүхийг зогсоох талаар засгийн газар түүштай ажиллаж чадахгүй байна гэдэгтэй та санал нийлэх үү: Тийм-62%
6. Эрүүдэн шүүхтэй тэмцэх нь таны үүрэг мөн үү: Тийм-65% гэж хариулсанас

үзэхэд эрүүдэн шүүх, зүй бус харьцах явдалтай тэмцэх, урьдчилан сэргийлэх механизмын хангальтгүй, хариуцлага тооцох эрх зүйн орчин дутмаг байгаа нь харагдах ба засгийн газраас эрүүдэн шүүхийн эсрэг конвенцийн хэрэгжилтэнд илүү анхаарал

хандуулан ажиллах шаардлагатай байна гэж дүгнэж болно.

Монгол улс дахь хорих, цагдан хорих газруудад гарч болзошгүй эрүү шүүлт, зүй бус харьцаанаас урьдчилан сэргийлэх хамгийн чухал алхам болох “Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцийн Нэмэлт Протокол”-д Монгол улс нэгдэн орохыг уриалсан захидал уриалгад 600 гаруй гарын үсэг цуглуулж Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Хууль зүй дотоод хэргийн сайд, Гадаад хэргийн сайд, УИХ-ын хууль зүйн байнгын хорооны дарга наарт тус тус илгээлээ.



Эрүүдэн шүүхийн хохирогсодод туслах Олон улсын өдрийн үйл ажиллагааг Ийгл, С-1, NTV зэрэг телевизээр олон нийтэд хүргэв. Мөн Ийгл телевизийн Зочны цагаар оролцон эрүү шүүлт, зүй бус харьцаа сэдвээр ярилцлаа.

Эрх чөлөөний Парад



9 дүгээр сарын 12-нд эрх чөлөөний талбайд болсон “Эрх чөлөөний Парад”-ын үеэр оюутны бүлгийн гишүүд Шихихутуг сургуулийн “Гэрэг” клубын гишүүдийн хамт “Хэн ч хязгаарлаж болохгүй эрх” уриан дор гүйлтийн тэмцээн зохиов. Цаазаар авах нь зохистой шийдэл биш, Үхэл жам ёсоороо ирвэл хэн ч зогсоож чадахгүй харин зориуд санаатайгаар хүний амийг авбал маш харамсалтай зэргээр Далай ламын хэлсэн үгээс иш татсан зэргээр хэн ч хязгаарлаж болохгүй эрхүүдийг илэрхийлсэн утга бүхий улаан өнгийн футболктой залуусын уран сэтгэмж бүхий гүйлтийн тэмцээн нь олны анхаарлыг ихэд татав

Эрүү шүүлтгүй Монгол улсын төлөө

Монгол улсын их сургуулийн Хууль зүйн



сургуулийн 4-р дамжааны 20 орчим оюутнууд Олон улсын хүний эрхийн Эмнести Интернэшил байгууллагын үйл ажиллагаатай танилцан, Эрүүдэн шүүхийн эсрэг кампанит ажлын хүрээнд “Эрүү шүүлтгүй Монгол улсын төлөө” ил захидалд гарын үсэг цуглуулав.

Хорих ангийн албан хаагчид болон нийгмийн ажилтнуудад сургалт



ШШГЕГ-ын харьяа хорих 413, 433-р ангийн хүсэлтийн дагуу 2009 оны 12-р сард “Эрүүдэн шүүхээс ангид байх хүний эрх” сэдвийн хүрээнд сургалт явууллаа. Сургалтанд хорих 413-р ангийн 56 албан хаагч нийгмийн ажилтнууд, 433-р ангийн 40 албан хаагч, нийгмийн ажилтнууд оролцлоо. Урьд өмнө нь хорих ангид явуулж байсан сургалтын санал асуулгаар сэргэл зүйн чиглэлийн сургалтыг авах хүсэлтийг хорих анги бүрээс гаргаж байсны дагуу “Стресс гэж юу болох, түүнийг удирдах, стресс орохгүй тулд харилцаанд анхаарах зүйлс” сэдвээр мөн сургалтыг үргэлжлүүлэв. Сургалтын явцад “Хоригдогсодын хүн гэсэн нэр төрийг нь хүндэтгэн харьцах ёстой” гарын авлагын дасгал ажлаар Хоригдолтой харьцах харилцаа, Материаллаг нөхцөл, дэглэм ба хамгаалалтын арга хэмжээ, Гадаад ертөнцтэй харьцаа, ашигтай хөдөлмөр, Эмнэлгийн үйлчилгээ, Хорих газрын албан хаагчид гэсэн бүлгүүдэд хуваагдан ажиллалаа.

413-р ангийн албан хаагчид дасгал ажилд идэвх сайтай оролцож байлаа. Тус ангийн албан хаагчид дасгал ажлын үеэр өөрийн анги дээр жишээ авч тусгай хэрэгслийг буруугаар ашигласан тохиолдолд тухайн албан хаагчид шийтгэл оногдуулсан жишээг ярьж байсан зэргээр алдаа дутагдлаа шударгаар хүлээн зөвшөөрч гаргаж ирж

байлаа. Хоригдол хоорондын харилцаанд үүссэн маргааныг шийдвэрлэхэд албан хаагчид ихээхэн бэрхшээлтэй тулгардаг нь ажиглагдаж байлаа.



433-р ангийн тухайд дасгал ажлын явцад зөвхөн хуулийн дагуу байх ёстой зүйл болон дотоод дүрэм журмынхаа дагуу тайлбар хийж байлаа. Гэвч тухайн хорих ангид материаллаг нөхцөл талаасаа зарим нэг алдаа дутагдал байгаа нь дасгал ажлын явцад ажиглагдсан. Мөн тухайн хорих анги нь орон нутгаас алслагдсан байгаагаас гадны сургалт цөөн очдог зэрэг хүчин зүйлүүдээс шалтгаалан 413-р ангитай харьцуулахад сургалтын идэвх, хандлага нь сул байв.

Сургалтын үеэр ихэнх албан хаагчид хорих ангийнхаа дотоод дүрэм журмыг сайтар судалсан нь сайшаалтай байсан боловч зарим нэг шинээр ажилд орсон албан хаагчид нь дотоод дүрэм журамтайгаа сайтар танилцаж амжаагүй нь дасгал ажиллуулах явцад харагдаж байлаа.

Хорих ангуудын удирдлагын зүгээс гадны байгууллагаас сургалт авах сонирхол ихээхэн байдаг ч төсөв мөнгө хүрэлцэхгүйн улмаас тэр бүр сургалт авч чадахгүй байгааг дурдаж байсан юм.

Хэвлэл мэдээлэл

Сэтгүүлчдийн бүлгийн гишүүдийн санаачилгаар Боловсрол сувгийн “Цонх” булангийн 12-р сарын 2 дахь долоо хоногийн нэвтрүүлгийг “Хүний эрх” сэдвийн хүрээнд зохион явуулав. Энэ хүрээнд эрүүдэн шүүх асуудлыг хөндсөн нэвтрүүлэгт хуульчдын бүлгийн гишүүн А.Түвшинтулга оролцож Монгол улс дахь эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх эрх зүйн орчин дутмаг, Эрүүгийн болон байцаан шийтгэх хууль тогтоомжинд Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцийн зүйл заалт бүрэн дүүрэн тусгагдаагүй байгаа эрүүдэн шүүгчдэд ял завших боломж олгож байгаа, эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх хамгийн үр дүнтэй чухал алхам болох Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцийн Нэмэлт Протоколд Монгол улс нэгдэн орох алхмыг авч хэрэгжүүлэх шаардлагатай байгааг олон нийтэд хүргэж чадлаа.

ЭДИЙН ЗАСАГ, НИЙГЭМ, СОЁЛЫН ЭРХИЙН ТӨЛӨӨХ КАМПАНИТ АЖИЛ (((ХҮНИЙГ ХҮНДЭЛ)))

Өнөөдөр дэлхий дээр 963 сая хүн өлсгөлон амьдарч, 1 тэрбум хүн ядуусын хороололд аж төрж, жирэмслэлтээс үдэн хором тутамд 1 эмэгтэй амиа алддаг, 1.3 тэрбум хүн эрүүл мэндийн наад захын үйлчилгээ авах боломжгүй, 2.5 тэрбум хүн зохих ариун цэвэр, усны үйлчилгээнд хамрагдаагүйгээс 20000 хүүхэд нас бардаг байна.

Энэтхэг, Бразил, Мексик зэрэг орнуудад эдийн засгийн хөгжлөөс үл хамааран угуул иргэдүүндсэн эрхээ эдэлж чадахгүй, Бирм, Хойд Солонгос, Зимбабве зэрэг улсад хүнсний бүтээгдэхүүний үнэ тэнгэрт хадаж улсын хувьд ядуурлын түвшин 35,2 хувь болж 100 хүн тутмын 35 нь зайлшгүй шаардлагатай хүнсний болон хэрэглээний зүйлээ худалдан авч чадахгүй байна (YCH).

Иймээс олон улсын хүний эрхийн Эмнести Интернэшил байгууллага нь эдийн засаг, нийгэм, соёлын эрхийг таниулах, нэр төртэйгээр амьдрах эрхийг хангах “Хүнийг хүндэл” кампанит ажлаа 2009 оны 5 дугаар сарын 28-нд бүх улс оронд нэгэн зэрэг эхлүүлсэн билээ. “Хүнийг хүндэл” кампанит ажил нь ядууралд хүргэж, түүнийг гүнзгийрүүлж байгаа хүний эрхийг зөрчих явдлыг зогсоох, түүнээс сэргийлэх зорилготой юм. Энэхүү кампанит ажил нь дараах 4 асуудал дээр ажиллаж байна.

1. Компаниудыг хариуцлагатай болгох: хариуцлагыг хүлээлгэхийг хууль ёсоор шаардах
2. Нөхөн үржихүйн гажуудал-эхийн эндэгдэл, нөхөн үржихүйн эрх
3. Суурьшилтай холбоотой хүний эрх: дэлхий даяарх ядуусын хороолол /албан бус суурьшил/
4. Хууль ёсны эрхийг баталгаажуулах: эрхийг хууль зүйн хувьд хүлээн зөвшөөрч, дагаж мөрдөх явдлыг сайжруулах

Энэхүү кампанит ажлын хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ:



Сургалтууд

1. 2009 оны 5-9 дүгээр саруудад гишүүддээ зориулж “Хүнийг хүндэл” кампанит ажлын танилцуулга, энэхүү кампанит ажлын хэтийн зорилго мөн бүлгүүдийн оролцооны талаар сургалт явуулан, хэлэлцүүлэг өрнүүллээ.
2. 2009 оны 5 дугаар сарын 22-нд ЭМЯ-тай хамтран 100 орчим өрхийн эмч нарт “Хүнийг хүндэл” кампанит ажлын талаар мөн эхийн эндэгдэл нь хүний эрхийн асуудал мөн гэсэн уриатайгаар сургалт зохион байгууллаа.
3. Эрдэнэтийн бүлгийн гишүүн С.Хажидмаа, Б.Өлзийбаяр нар Эрдэнэт хотын Дэнж багийн засаг даргын тамгын газартай хамтран Хүний эрхийн сургалтыгамжилттай зохион байгууллаа. Сургалтаар Эмнести Интернэшилийн тухай ойлголт, ЭЗНСЭ, “Хүнийг хүндэл” кампанит ажлын танилцуулга, Хүүхдийн эрхийн тухай ойлголт, Охидод аюулгүй сургуулийн талаар танилцуулж, “Ядуурал миний бодлоор” чөлөөт хэлэлцүүлэг зохион байгуулав.
4. Бид 2009 оны 10 дугаар сарын 30-нд уул уурхайн олборлолт хайгуулын ажилтнуудад сургалт зохион байгуулсан юм. Хүний эрх гэж юу болох, компанийн нийгмийн хариуцлагад



юуг ойлгох, хэрхэн хэрэгжүүлж болох талаар тайлбарлан, нийгмийн хариуцлагатай байснаараа ямар үр дүнд хүрч болох, олон улсын эрхзүйн зохицуулалт, худалдааны байгууллага, ажилчдын хооронд үссэн хүний эрхийн зөрчилд олон улсын механизмыг хэрхэн хэрэгжүүлэх талаар сургалтын агуулга чиглэгдсэн байлаа.

5. МИУ олон улсын их сургууль дээр 2009 оны 11 дугаар сарын 13-ны өдөр Эмнести Интернэшнл гэж юу вэ? ЭЗНСЭ гэж юу вэ сэдвүүдээр сургалт явагдсан бөгөөд Эмности Интернэшнлийн зорилго, үйл ажиллагаа, “Хүнийг хүндэл” кампанитажлыг танилцуулж, МХЗ-ын асуудлаар хэлэлцүүлэг өрнүүллээ.



“Таны үгийг сонсъё” аян

Эмности Интернэшнл байгууллагын Ази Номхон Далайн Бүсийн Залуучуудын Сүлжээ нь “Хүнийг хүндэл” кампанит ажлын хүрээнд 15000 иргэдээс “Нэр төртэй амьдрах нь таны хувьд ямар утга учир агуулсан эсэх, таны бодлоор ядуурал гэж юу вэ? Ядуурлаас яаж гарах вэ” гэдэг талаар иргэдийн үгийг сонсож байгаа билээ.



Монголын Эмности Интернэшнлийн гишүүд мөн энэхүү аяны хүрээнд Баянгол, Баянзүрх, Хан-Уул, Сонгинохайрхан, Сүхбаатар дүүргүүд, Хэнтий аймгийн Биндэр сум мөн Орхон аймгийн Эрдэнэт хотын 300 гаруй иргэдээс сэргэгдлийг нь сонссон юм. 2011 онд Эмности Интернэшнлийн 50 жилийн ойгоор иргэдийн дуу хоолойг нэгтгэж засгийн газар, НҮБ болон бусад холбогдох газруудад хүргэх юм.

Ядуурлыг эсрэг олон улсын өдөр

Ядуурлын эсрэг олон улсын өдрийг угтай Нийслэлийн Засаг даргын тамгын газар, Нийслэлийнхаламжийнүйлчилгээнийгазар, төвиийн 6 дүүргийн хөдөлмөр халамжийн үйлчилгээний хэлтсүүдтэй хамтран “Хүнийг хүндэл” өдөрлөгийг Сүхбаатарын талбайд 2009 оны 10 дугаар сарын 16-ны өдөр зохион байгуулсан билээ.

Энэ үеэр хүний эрхтэй холбоотой зурагт хуудасны үзэсгэлэнг олон нийтэд үзүүлсэн бөгөөд “Хүнийг хүндэл” арга хэмжээтэй холбоотой гарын авлага тараан холбогдох мэдээллийг олон нийтэд хүргэсэн юм. Харин Нийслэлийн халамжийн үйлчилгээний газар, дүүргүүдийн хөдөлмөр халамжийн үйлчилгээний хэлтсүүдээс Засаг даргын мэрийн хөтөлбөрт заасан 4579 өрхийг ядуурлаас гаргах ажлын хүрээнд хийгдсэн ажлуудыг олон нийтэд тайлагнав.

Нөлөөллийн ажил

Олон улсын хүний эрхийн өдрөөр УЗ-ийн дэд дарга М.Чимиддорж “Боловсрол” телевизийн цуврал нэвтрүүлэгт оролцлоо. Нэвтрүүлгийн гол зорилго олон нийтэд хүний эрхийн талаар мэдээлэл өгөх мөн дэлхий даяар өрнүүлээд байгаа “Хүнийг хүндэл” кампанит ажлыг сурталчлах явдал байв. Ядуурал гэж юу болох, Монгол улсын болон бусад орнууд дахь ядуурлын түвшинг тоо баримтаар танилцуулсан юм.

Бидний “Хүнийг хүндэл” кампанит ажлын сурталчилгааг NTV, C1, S Music, Боловсрол суваг дэмжиж үнэ төлбөргүйгээр гаргасан юм.

Энэхүү кампанит ажил нь 6 жил үргэлжлэх бөгөөд бид энэ жил сургалт зохион байгуулж, чадавхи бэхжүүлж, бэлтгэл ажлыг хангалаа. Дараа дараагийн жилд бид Үндэсний хөтөлбөр боловсруулах, туншлэх, стратегийн ач холбогдол бүхий оролцогчид, хүмүүстээ асуудлаа хүргэхийг зорино.



Чи өөрөө гэрэл

Нарны гэрэл мандана гэвч
Чиний дээр сүдэр байна хараач
Хүн бухэн тэгш эрхтэй гэвч
Хөөрхий зарим нь мэдэхгүй даанч
Дутуу зуиль чи мэдэрч байв уу
Ядуурал хэмээх шоронг чи үзэв үү
Хатуу хөрсөнд харанхуй шөнөөр ч
Сарны гэрэл бол чиний явах зүг

Гэнэт харанхуйлж ширэнгэнд айdas түгэнэ
Гэвч гэрэл цацархад тэнд араатан гэж үгүйээ
Хүнийг мөлжигчид тэнд чамайг тойрон эргэнэ
Хүнийг хүндэлсэн цагт тэд нар бүгд үгүй

Харанхуйд алхсан чи үл эцнэ
Хамаг нууц нь чи өөрөө – өөрөө гэрэл

Үг хэлэх, өөрийгөө илэрхийлэх
Өнгө мөнгө үл хамаарч өмгөөлүүлэх
Аль аль нь чамд бий түүнд ч бий
Алаг дэлхийд амьд явах эрхтэй
Мөнгөгүй байж болно гэхдээ
Эрхгүй байх боломж үгүйээ
Эдийн засаг, улс төр хямардаг ч
Хүний эрх харин хэзээ ч үгүй, үгүй ээ

Гэнэт харанхуйлж ширэнгэнд айdas түгнэ
Гэвч гэрэл цацархад тэнд араатан гэж үгүй ээ
Хүнийг мөлжигчид тэнд чамайг тойрон эргэнэ
Хүнийг хүндэлсэн цагт тэд нар бүгд үгүй

Харанхуйд алхсан чи үл эцнэ
Хамаг нууц нь чи өөрөө - өөрөө гэрэл

Хэн ч бай хүнийг дарамталж болохгүй
Хүний эрхийг хэнээ ч харамлаж болохгүй
Хэнд ч дарлуулж, хэнд ч айлгуулж
Хэн нэгнийг бурхан шиг тахин шүтэх хэрэггүй
Яагаад бидний бидний боломж адилхан
Яагаад гэвэл бидний биологи адилхан
Яагаад гэвэл би, яагаад гэвэл чи
Яагаад гэвэл бүгд хүн гэдэг амьтан
Хайж байсан бид аюулгүй байдлыг
Айж явсан бид аянгат мөндрөөс
Шивнэж байсан бид тэнгэр дуугарахад
Харин одоо хэрэггүй хаалга тэнд

Гэнэт харанхуйлж ширэнгэнд айdas түгнэ
Гэвч гэрэл цацархад тэнд араатан гэж үгүйээ
Хүнийг мөлжигчид тэнд чамайг тойрон эргэнэ
Хүнийг хүндэлсэн цагт тэд нар бүгд үгүй

Гэнэт харанхуйлж айdas түгнэ
Гэрэл цацархад араатан гэж үгүй ээ
Харанхуйд алхсан чи үл эцнэ
Хамаг нууц нь чи өөрөө – өөрөө гэрэл

Чи өөрөө – Хамт нааш ир жаалуудаа
Чи өөрөө – Хамт нааш ир найзуудаа
Чи өөрөө – Хамт нааш ир залуусаа
Чи өөрөө – Хамт нааш ир хүмүүсээ

Дуучин Батцэнгэл (*Quiza*), дуучин Агиймаа, Одноо, Тэмүүлэн, ВХ, Тэнүүнтэй хамтран энэхүү үйл ажиллагааны хүрээнд “Чи өөрөө гэрэл” дууг дуулж олон нийтэд хүргэлээ.

“ЭМЭГТЭЙЧҮҮДИЙГ ХҮЧИРХИЙЛЭХИЙН ЭСРЭГ” КАМПАНИТ АЖИЛ

“Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг таслан зогсооे” кампанит ажлын хүрээнд Монголын Эмнести Интернэшнл 2009 онд дараах зорилгын дагуу ажиллалаа.

- Нийгмийн бүх давхаргад хүйсийн тэгш байдлын зарчмыг хэвшигүүлэх.
- Эмнести Интернэшнлийн ажилд мэргэжлийн бүлгүүд болон олон нийтийн дэмжлэгийг авах.
- ЭЭХТЗ кампанит ажлын үеэр МЭИ-д эрэгтэйчүүд болон залуучууд элсэхийг дэмжих.
- Олон улсын хэмжээнд эмэгтэйчүүдийн кампанит ажилд оролцож эв санааны нэгдлээ илрэхийлэх.



Сургалтууд

- Бид гишүүдээ чадавхжуулах үүднээс хэд хэдэн сургалтыг явууллаа. Уз-ийн гишүүн А.Отгончимэг залуу гишүүддээ “Сайн дурынхан гэж хэн бэ?”, “Сан арвижуулалтыг хэрхэн хийх вэ” гэсэн сэдвүүдээр сургалт хийсэн бөгөөд эмч, эмэгтэйчүүдийн бүлгийн гишүүд хамрагдсан юм.
- Мөн Монфемнэт эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах ТББ-уудын сүлжээний ажилтан Х.Номингэрэл “Жендер гэж юу вэ?” сургалт,

чөлөөт ярилцлагыг хийж гишүүдэд жендерийн талаарх ойлголт өгсөн юм. Сайн дурын ажилтан Кристина Жосстай хамтран “Англи хэл дээр илтгэл хэрхэн тавих вэ?”, “Сан арвижуулах үйл ажиллагааг гадаадын орнууд хэрхэн хийдэг” талаар чөлөөт ярилцлага, туршлага судлах сургалтыг зохион явуулсан юм.

- Эмэгтэйчүүдийн бүлэг, эмч нарын бүлгийн хамтарсан сургалтыг 4 дугаар сарын 20-нд БЗД-ийн 8 дугаар хороонд зохион байгуулсан. Сургалтын үеэр “Шороон самбар” баримтат кино үзэн хэлэлцүүлэг өрнүүлж, эмэгтэйчүүдийн эрх, эрүүл мэнд, нөхөн үржихүйн асуудлаар Б.Мөнхжавхлан, Ц.Эрдэнэбулаг нар тайлбар өглөө.
- “Хүний эрхийн сургагч багш”-ийн сургалтанд хамрагдсан Г.Наранцэцэг, Я.Мөнхчимэг нар баталгаажуулах сургалтыг 6 дугаар сарын 5-нд СБД-ийн 8 дугаар хорооны эмэгтэйчүүд, нийгмийн ажилтан, зохицуулагч нарын дунд зохион байгуулсан юм. “Хүний эрх ба хүний наймаа” гэсэн уг кино хичээлийг Багш нарын бүлгийн гишүүн Ш.Пүрэвбаатартай хамтран амжилттай зохион байгуулж сертификат гардлаа.
- “Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг таслан зогсоох 16 хоногийн аян”-ны хүрээнд Эмэгтэйчүүдийн бүлэг 19-р сургууль дээр хүний эрх, жендерийн талаар сургалт хийллэ. Сургалтаар ЭЗНСЭ, “Хүнийг хүндэл” кампанит ажлыг танилцуулж, “Жендерийн тухай бидний ойлголт” сэдвийн хүрээнд сурагчидтай чөлөөт ярилцлага хийсэн юм. Мөн Канад, Съерра Леон, Энэтхэг улсууд руу илгээх захидал уриалгад гарын үсэг зурууллаа.

Кино хэлэлцүүлэг

Эмэгтэйчүүдийн эрхийн өдрийг угтан З дугаар сарын 6-нд Эмэгтэйчүүдийн бүлгийн гишүүн, зохиолч Б.Шүүдэрцэцэг, МУИС-ийн философиин



тэнхмийн багш М.Огонбаяр нартай хамтран МУИС-ийн 300 гаруй оюутан залуусын дунд "Эмэгтэйчүүдийн эрх - Монгол дахь феминизм" кино хэлэлцүүлэг зохион байгуулсан юм. Уг кино хэлэлцүүлгээр эмэгтэйчүүдийн эрхийн талаар ойлголт өгөх, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг хүлээн зөвшөөрдөг нийгмийн хандлагыг өөрчлөх талаар ярилцсан юм. Мөн залуусыг Иран, Афганистан, Балба, Либери дахь эрх нь зөрчигдэж буй эмэгтэйчүүдийн төлөө гарын үсэг зуруулах үйл ажиллагааг зохион байгуулав. Тус сургалтыг "Ач" анагаах ухааны сургуулийн оюутнуудын дунд зохион байгуулсан бөгөөд эмэгтэйчүүд, эмч нарын бүлгийн гишүүд сайн дураараа ажилласан юм.



Сарнайн өдөр

Эмэгтэйчүүдийн бүлэг 5 дугаар сарын 16-ны өдөр "Сарнайн өдөр" үйл ажиллагааг зохион явууллаа. Энэ өдрийн үйл ажиллагаа нь "Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг таслан зогсоо" кампанит ажлыг сурталчлах, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн хор уршгийг нийтэд ойлгуулах, дэлхий дээр эрх нь зөрчигдөх буй эмэгтэйчүүдийн төлөө гарын үсэг цуглуулах зорилготой байсан юм.

Тус өдөрлөгийг МУИС-ын хоёрдугаар байрны өмнө зохион байгуулсан бөгөөд уг үйл ажиллагаанд Эмэгтэйчүүд, залуучуудын бүлгийн идэвхтэн гишүүд оролцлоо. Өдөрлөгийн үеэр "Хэн хүний эрхийн төлөө шилдэг уриа бичих вэ?" граффити бичлэгийн уралдаан зохиогдсон. Энэ уралдаанд ШУТИС-ийн Үйлдвэр Дизайны сургуулийн З дугаар курсийн оюутны "Юнайт 5" багийнхан амжилттай оролцсон юм. Гэр бүлийн хүчирхийлэлд өртөж



зовж буй эмэгтэйчүүдийн төлөө Армян, Венесуэл улсын эрх баригчдад хандсан захидалд 564 гарын үсэг цуглууллаа. Уг өдөрлөгийн үйл ажиллагааг Зууны мэдээ, Монголын мэдээ, MYONPT, SBN телевиз сурвалжлан мэдээллээ.

"Be" өдөрлөг

7 дугаар сарын 26-нд "Ньютел" ХХК-ны "Be" үйлчилгээний төвийн урд талбай дээр гишүүд идэвхижүүлэх үйл ажиллагаагаа явууллаа. Энэ үеэр бид сан арвижуулах зорилгоор "Хүний эрхийн бинго"-г иргэдийн дунд зохион байгуулж хүний эрх, Эмнестигийн үйл ажиллагааг сурталчилан гарын авлага сэтгүүлүүдийг иргэдэд тараалаа. Бас "Эрхээ мэдвэл шоколад шиг амтагдана" асуулт хариултын тэмцээн зохион байгуулсан юм. Энэ үеэр элссэн гишүүдээ бид 8 дугаар сарын 1-нд болсон Эмнестигийн сайн дурынхны өдөрлөгт урьж оролцууллаа. Ньютел корпораци бидэнд талбайгаа гаргаж өгч бидний ажлыг дэмжлээ.

Нөлөөллийн ажил

"Эрхийнхээ төлөө гарaa өргөцгөө" залуусын хүний эрхийн аяны хүрээнд 9 дугаар сарын 12-нд болсон "Хүний эрхийн парад"-д эмэгтэйчүүдийн бүлэг "Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг таслан зогсоо" кампанит ажлыг хариуцан, T-shirt fashion show-г анх удаа зохион байгуулсан ба энэ үйл ажиллагаанд эмэгтэйчүүдийн бүлгийн гишүүн Азийн Модель агентлагийн тэргүүн Ч.Содтуяа шавь нартайгаа оролцон хамтран ажиллалаа. Мөн захидалuri алгад иргэдээс 500 гаруй гарын үсэг цуглуулсан юм.

УЛС ОРНУУДЫН ТӨЛӨӨХ КАМПАНИТ АЖИЛ

Энэхүү кампанит ажлын хүрээнд Монголын Эмнести Интернэшнл 2009 онд дараах зорилгын дагуу ажиллалаа:

- Хүний эрхийг хамгаалагчдын талаар соён гэгээрүүлэх үйл ажиллагаа зохион байгуулах.
- Өмнөд Солонгосын Засгийн Газрыг "Бүх цагаач ажилтан ба тэдний гэр бүлийн гишүүдийн эрхийг хамгаалах тухай олон улсын конвенц"-ийг батлахыг шаардан нөлөөллийн үйл ажиллагаа өрнүүлэх.
- Кампанит ажлыг үр нөлөөтэй хэрэгжүүлэх бөгөөд олон оролцогчдын тоог хангах.

Цагаач ажилтан

2009 оны 4 дүгээр сарын 16-нд БНСҮ-ын ХЭК-ын цагаач ажилтны асуудал хариуцсан төлөөлөгч ноён Мун Ён-Хуныг ҮЗ-ийн дэд дарга М.Чимиддорж кампанит ажлын зохицуулагч Э.Огтончuluун нар хүлээн авх уулзлаа. Энэ үеэр цагаач ажилтны эрх ашгийн талаар БНСҮ-д ажиллаж буй Монгол иргэдийн талаар санал бодлоо солилцов. Эмнести Интернэшнл байгууллага нь БНСҮ-ын засгийн газрыг "Бүх цагаач ажилтан ба тэдний гэр бүлийн гишүүдийн эрхийг хамгаалах тухай олон улсын конвенц"-ийг батлахыг шаардаж кампанит ажил өрнүүлээд байгаа билээ.

Олон улсын хамтын ажиллагаа

2009 оны 4 дүгээр сарын 17-нд мөн 7 дугаар сарын 21-нд Нидерландын Вант улсын Бээжин дахь ЭСЯ-ны улс төрийн асуудлыг хариуцсан нэгдүгээр нарийн бичгийн дарга хатагтай Вера Вромен цагаач асуудлыг хариуцсан туслах ажилтан хатагтай Марике Шуллер нарыг гүйцэтгэх захидал Б.Алтантуяа, кампанит ажлын зохицуулагч Э.Огтончuluун, Г.Амарзаяа нар хүлээн авч уулзлаа. Энэ үеэр Монгол дахь хүний эрхийн байдлын талаар санал бодлоо солилцож сонирхолтой яриа өрнүүлсэн юм.

Хүний эрхийн хамгаалагчид

- Ан Сан Су Чигийн төрсөн өдрөөс /6 дугаар сарын 19/ хэдхэн хоногийн өмнө дэлхийн өнцөг булан бүрээс 100 гаруй улс төрийн хориглууд түүнийг суллаж, Бирмд зэвсгийн хориг тавихыг НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлд шаардсан мэдэгдэлд өөрсдийн нэрээ бичиж үлдээлээ. Тэдгээр хүмүүсийн дунд БНСҮ-ын Ерөнхийлөгч асан, Нобелийн энх тайвны шагналт Ким Дэ Жун, Польшийн Ерөнхийлөгч асан, Нобелийн энх тайвны шагналт Лех Валенса, БНСҮ-ын Ерөнхийлөгч асан, зохиолч Вацлав Хавел зэрэг хүмүүс гарын үсэг зурлаа. Монголын хувьд гэвэл сэтгүүлч Г.Жамьян, хуульч Л.Санжаасүрэн, генерал Баатар зэрэг хүмүүс дуу хоолойгоо нэгтгэв. Эдгээр хүмүүсийн дуу хоолойг www.64forSuu.org цахим хуудсан

дээр байрлуулсан байгаа билээ.

- Хятадын иргэн, эрдэмтэн Лю Шибао 2009 оны 6 дугаар сарын 23-нд төрийн эсрэг гэмт хэрэг өдүүлсэн хэмээгдэн баривчлагдсан бөгөөд түүнд өмгөөлөгчтэйгээ уулзах боломж олгохгүй байгааг эсэргүүцэн гарын үсэг зуруулах аяng зохион байгууллаа. Эмнести Интернэшнл Хятадын засгийн газрыг Лю Шибаог яаралтай суллах, хорих газар түүнд эрүү шүүлт тулгаж байгаа эсэхийг шалгах, өмгөөлөгч, гэр бүлийнхэнтэйгээ уулзах боломж олгох, улс төрийн шинэчлэл хүсч үзэл санаагаа илэрхийлэгсдийг гэмт хэрэгтэнд тооцон баривчлах явдлыг зогсоохыг шаардсан бөгөөд иргэдээс нийт 446 гарын үсэг цуглувуж Хятадын эрх баригчдад илгээлээ.

Захидалuriалгын марафон

Бид жил бүрийн 12 дугаар сарын 10 буюу Олон улсын хүний эрхийн өдрөөр хүний эрхийн төлөө захидал уриалга бичих марафоныг дэлхий даяар нэгэн зэрэг явуулдаг билээ. Энэ жил нийт 30 гаруй оронд энэхүү үйл ажиллагаа явагдсан юм.

Монголын Эмности Интернэшнл энэхүү үйл ажиллагаагаа 12 дугаар сарын 10-ны өдөр Скай Их дэлгүүр, Тэнгис кино театр, Меркури худалдааны төв, Отгонтэнгэр Их Сургууль, МУИС-ийн ОҮХС, Хобби ЕБС, Монгол-Энэтхэгийн хамтарсан сургууль дээр "Нэг хүний амь, Нэг гарын үсэг, Нэг зуун төгрөг" уриан дор зохион байгуулж, Хятад, Орос, Балба, Энэтхэг, Сьерра Леон, Канад, Израиль улсад эрх нь зөрчигдсөн хүмүүсийн төлөө 3862 гарын үсэг зуруулж илгээлээ.



Эмнэсти Интернэшнлийн судлаачдын айлчлал



Эмнэсти Интернэшнлийн Зүүн Азийн багийн дэд дарга Розеан Райф, кампанит ажлын зохицуулагч Кэтрин Барракло 2009 оны 7 дугаар сарын 18-наас 8 дугаар сарын 1-ний өдруудэд Монголд айлчилсан юм. Уг айлчлалын гол зорилго нь Монгол дахь хүний эрхийн өнөөгийн нэхцөл байдалтай танилцах, 2008 оны 7 дугаар сарын 1-ний үймээн самууны асуудлыг нягтлах

явдал байв. Айлчлалын үеэр тэд ерөнхийлөгч Ц.Элбэгдорж, ХЭДХЯ, ХЭҮК, УЕП дэргэдэх МБА, МӨХ, ЦЕГ, ТСБ-ны 111-р буюу Дэнжийн мянга, Ганц худаг, ЭСЯ мөн бусад төрийн болон төрийн бус байгууллагуудын төлөөлөгчид, Монголын Эмнэсти Интернэшнлийн Удирдах зөвлөл болон Гүйцэтгэх товчооны ажилчидтай уулзсан юм.

2009 оны 12 дугаар сарын 18-нд “Би эндээс хаачих вэ. 2008 оны 7 дугаар сарын 1-нд Монголд болсон үйлявдлын сургамж” тайлан илтгэлийг танилцуулах хэвлэлийн бага хурал хийв. 30 орчим төрийн болон ТББ-ын төлөөлөл оролцсон уг хуралд УЗИЙН дарга Р.Янжмаа нээлт хийж, Гүйцэтгэх захирал Б.Алтантуяа илтгэлийн талаарх танилцуулга хийсэн билээ. Зочид Лондон дахь Эмнэсти Интернэшнл байгууллагын кампанит ажлын зохицуулагч Кэтрин Барраклотай шууд онлайнаар холбогдон өөрсдийн хүссэн асуултандаа хариултаа авсан нь энэхүү хэвлэлийн бага хурлын онцлог байлаа. Eagle TV, TV9, “Зууны мэдээ” сонины, “Үнэн” сонины сурвалжлагч нар ирсэн байв.

Эмнэсти Интернэшнл байгууллага нь дараах зөвлөмжийг хууль сахиулах байгууллагын албан тушаалтнуудын үйл ажиллагааг зохицуулах үүрэг бүхий холбогдох байгууллагуудад хандаж гаргав.

Монгол Улсын Засгийн газарт:

- Хууль сахиулах байгууллагын албан тушаалтнуудад шаардлагагүй үед хүч хэрэглэх, хүч хэтрүүлж хэрэглэх, эрүүдэн шүүх, бусад хэлбэрээр зүй бусаар харьцах явдлыг бүх нэхцөл байдалд бүрэн хориглох бөгөөд ийм үйлдэл эрүүгийн ба сахилгын мөрдөн шалгах ажиллагаа явуулж эрүүгийн хэрэг үсгэх болно гэсэн тодорхой санамж мэдээллийг хүргэж, хууль сахиулах байгууллагын ахлах албан тушаалтнуудад ийм санамж мэдээллийг удирдлагадаа байгаа хүмүүст хүргэх даалгавар өгөх
- НҮБ-ын Эрүүдэн шүүх ба бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэх асуудал эрхэлсэн Тусгай илтгэгчийн зөвлөмж зэрэг эрүүдэн шүүх, бусад хэлбэрээр зүй бусаар харьцахаас урьдчилан сэргийлэх талаар гаргасан шинжээчдийн зөвлөмжийг хэрэгжүүлэх талаар яаралтай арга хэмжээ авах
- Хүний эрхийн үндэсний комиссыг эрүү шүүлтийн хохирогсадын хохирлыг барагдуулах, тэднийг нийгэмшүүлэх арга хэмжээ авах нөхцлийг бүрдүүлэх замаар эрүүдэн шүүсэн тухай өргөдөл гомдлыг шийдвэрлэх чадавхи, эрх мэдэлтэй болгож, тус байгууллагын бие даасан байдал, чадавхийг бэхжүүлэх арга хэмжээ авах
- Улсын Ерөнхий прокурорын дэргэдэх Мөрдөн байцаах албыг хуулийн байгууллагын албан тушаалтнуудын талаарх хүний эрхийн зөрчил, гэмт хэргийн тухай өргөдөл гомдлыг шуурхай, хараат бусаар, шударгаар, бүрэн шалгаж шийдвэрлэдэг болгохын тулд тус байгууллагын төсөв санхүүжилтийг хангалттай хэмжээнд байлгаж, хэрэг шалгаж шийдвэрлэх ажиллагааг үндэслэлгүйгээр саатуулах, хойшлуулах боломж нөхцлийг цаашид гаргуулахгүй байх журмыг бий болгох
- Холбогдох гэрээ конвенцийдийн хэрэгжилттэй холбоотой хугацаа хэтэрсэн бүх тайланг гаргах ажлыг даруй эхэлж НҮБ-ын гэрээний хэрэгжилтийг хянадаг байгууллагуудад нэн даруй хүргүүлэх

ҮИХ-ын гишүүдэд:

- Хүний эрхийг ноцтойгоор зөрчигчдөд ял завшуулахгүй байхын тулд Эрүүгийн хуулийн 44 дүгээр зүйлийн 1 дэх заалтыг хасах буюу өөрчлөх замаар НҮБ-ын Эрүүдэн шүүх ба бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцид заасан тодорхойлолтын дагуу эрүү шүүлтийг гэмт хэрэг гэж тодорхойлж, Эрүүгийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах
- НҮБ-ын Эрүүдэн шүүх ба бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцийн Нэмэлт Протоколыг соёрхон батлах
- Парламентын Хүний эрхийн дэд хорооны ажлын хэсгийн тайлан, дүгнэлтийг олон нийтэд танилцуулж ажлын хэсгээс гаргасан зөвлөмжүүдийг шуурхай, үр дунтэй хэрэгжүүлэхийн тулд тэдгээрийн мөрөөр арга хэмжээ авч ажиллах

Цагдаагийн ерөнхий газарт:

- Жагсаал, цуглааны үеэр дэг журмыг сахиулах үед хүч хэрэглэх зэрэг цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг НҮБ-ын Хууль сахиулах байгууллагын албан тушаалтнуудын ажиллах зарчим, НҮБ-ын хүч, галт зэвсэг хэрэглэх тухай үндсэн зарчмууд зэрэг олон улсын хүний эрхийн стандартад нийцүүлсэн тодорхой дурэм журам, бодлого, сургалтын хөтөлбөр санаачилан боловсруулах
- НҮБ-ын Хүч, галт зэвсэг хэрэглэх тухай үндсэн зарчмууд ба олон улсын бусад баримт бичгүүдэд заасан онцгой тохиолдоос бусад үед хүч хэрэглэхгүй байх нөхцлийг бүрдүүлэх. Хүч хэтрүүлэн хэрэглэсэн буюу хүний эрхийн бусад зөрчилд холбогдсон этгээдийг заавал шалгах буюу арга хэмжээ авах болно гэдгийг цагдаагийн бүх ажилтанд ойлгуулах
- Нулимс асгаруулагч, бороохой, цахилгаан бороохой, резинэн бороохой, галт сум хэрэгсэлийг хэрэглэх дадлагатай хууль сахиулах ажилтнуудад ийм хэрэгслийг ашиглах зөвшөөрөл олгох
- Прокурорын байгууллага нь хүний эрхийн зөрчил гаргасан хууль сахиулах байгууллагын албан тушаалтнуудын үйлдлийн талаарх аливаа гомдол буюу мэдээллийг хүлээн авч шалгадаг болохыг цагдаагийн ажилтнуудад ойлгуулах. Ийм хэрэгт сэжиглэгдэн шалгагдаж буй албан тушаалтныг дахин гэмт хэрэг, зөрчил үйлдэхээс нь урьдчилан сэргийлэх, мөрдөн байцаалтын ажилд саад учруулахгүйн тулд эрхэлж буй албан тушаалаас нь түдгэлзүүлэх. Түүнчлэн тохиромжтой нөхцөлд сахилгын арга хэмжээг авах санаачлага гаргах хэрэгтэй
- Эрүүдэн шүүх, бусад хэлбэрээр зүй бусаар харьцах тохиолдол гарч болзошгүй нөхцөл байдал харуулах бий болсон тохиолдолд албаны дурс, дууны хяналтын бичлэгийг нэвтрүүлэх яаралтай арга хэмжээ авах. Эдгээр бичлэгийг шаардлагатай үед хэргийг шалгаж буй хүмүүст үзүүлэхийн тулд хангалттай хугацаанд найдвартай газар хадгалах ёстой

Улсын Ерөнхий прокурорын газарт:


- Хүний эрхийн зөрчлийн талаарх аливаа гомдол мэдээллийг шуурхай, хараат бусаар, шударгаар, бүрэн хянан шийдвэрлэх, гэм буруутай этгээдүүдэд ял завшуулахгүйбайх нөхцлийг бүрдүүлэх. Мөрдөн байцаалтын ажиллагааг мэргэжлийн өндөр урчадвартай, шударга, аль нэг байгууллага, хэн нэгэн албан тушаалтнаас хараатбус байж чадах ажилтнуудаар гүйцэтгүүлэхэд анхаарах
- Хууль хэрэгжүүлэх байгууллагуудын албан тушаалтнуудын талаар гомдол гаргахыг хүсч буй хүн ямар нэг саад бэрхшээлгүйгээр гомдлоо цаг тухайд нь гаргах, уг гомдлыг хугацаанд нь шударгаар шалгаж шийдвэрлэх үр дүнтэй механизмыг бий болгох. Гомдол мэдээллийг хүлээн авах боломжгүй гэж буцаахдаа буцааж буй үндэслэл тайлбараа тодорхой дурдаж, уг шийдвэрт давж заалдах боломж болон гомдлыг бусад аргаар шийдвэрлүүлж болох боломжийн талаар зөвлөгөө, мэдээллийг өгч байх
- Гомдол гаргагч, гэрч, өмгөөлөгчид бусад хүмүүс ямар нэг болзошгүй сүрдүүлэг, хучирхийллээс хамгаалагдсан байх нөхцлийг бүрдүүлэх

Шүүх эрх мэдлийн байгууллагуудад:

- Эрүүдэн шүүх, бусад хэлбэрээр зүй бусаар харьцсан үйлдлийн улмаас хийсэн гэж тогтоогдсон аливаа мэдэгдлийг шүүн таслах аливаа ажиллагаанд нотлох баримт болгохгүй харин эрүү шүүлт тулгасан хэмээн буруутгагдсан хүний эсрэг мэдэгдэл хийгдсэн тухай нотлох баримт болгон ашиглаж болно гэдгийг анхаарах.
- Хууль сахиулах байгууллагын албан тушаалтнуудын үйлдсэн хэргийн хохирогсад үр дүнтэй хуулийн хамгаалалт авах, олон улсын стандартын дагуу тэдэнд нөхөн төлбөр олгох, нийгэмшүүлэх, сэтгэл зүйн таатай нөхцлийг бүрдүүлэх, хэрэг зөрчил давтагдахгүй байх баталгаа гаргуулах зэрэг хангалттай нөхөн төлбөр авах нөхцлийг бүрдүүлэх.

Олон улсын хамтын нийгэмлэгт:

- Жагсаал, цуглааны дэг журмыг сахиулах үед цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг олон улсын хүний эрхийн стандартад нийцүүлэхийн тулд журам, бодлого боловсруулах, сургалт зохион байгуулахад техникийн ба санхүүгийн дэмжлэг үзүүлэх
- Улсын Ерөнхий прокурорын дэргэдэх Мөрдөн байцаах алба ба Монгол Улсын Хүний эрхийн үндэsnий комисст эдгээр байгууллагын эрх мэдэлд заасны дагуу үүргээ биелүүлэхэд хэрэгцээтэй чадавхи, хөрөнгөтэй болгох үүднээс техникийн ба санхүүгийн туслалцаа үзүүлэх.



ХҮНИЙ ЭРХИЙН БОЛОВСРОЛ

Монголын Эмнэлийн Интернэшил байгууллагын үйл ажиллагааны томоохон хэсэг хүний эрхийн боловсролын асуудалд төвлөрдөг бөгөөд хүний эрхийн талаар нийгмийн олон салбарт соён гэгээрүүлэх ажиллагаа явуулж байна.

2009 онд хүний эрхийн боловсролыг стратегитэй хүргэх, хүний эрхийн боловсрол олгох шинэ арга зүйг түгээн дэлгэрүүлэх, дунд сургуулиудад хүний эрхийн зөв жишиг хандлага тогтоох, олон улсын хүний эрхийн хэм хэмжээг дагаж мөрдөх тогтолцоо бүрдүүлэх, хүний эрхийн боловсролыг нийгэмд үр дүнтэй өөрчлөлт хийх хэрэгсэл болгон ашиглах зорилготой ажиллалаа.

Хүний эрхийн боловсрол нь НҮБ-ын Хүний эрхийн боловсролын Дэлхийн хөтөлбөрт тодорхойлсоноор “Хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх, хүнийг төвдөө тавьсан нийгмийн хөгжил, зүй ёсыг дэмжих, мэдлэг, чадвар, хандлагыг хөгжүүлэх, хуваалцах, түгээн дэлгэрүүлэхэд чиглэсэн мэдээлэл, сургалт, боловсролын үйл ажиллагаа” байдаг. Угтаа хүний эрхийн боловсрол нь “хүнд өөрийн эрх бий гэдгийг нь ойлгуулж, эрхээ өдлэх, эрхээ хамгаалах, хуулийг ойлгож, хэрэглэхэд нь туслахад” зориулагддаг билээ. Эрхээ мэдсэнээр хүмүүс өөрийгөө нийгэмд хэрхэн аж төрж байгаагаа, ямар асуудлуудаас болж бэрхшээлтэй тулгарч байгаагаа мэдэж, шийдвэрлэх арга замаа олж чаддаг болдог. Хүний эрхийн боловсролын үйл ажиллагаа нь стратеги төлөвлөгөөний хүрээнд олон жилээр зорилго зорилтоо тодорхойлон идэвхитэй тогтмол хэрэгжиж буй анхдагч хөтөлбөрийн нэг бөгөөд 2009 оны хувьд дараах үйл ажиллагааг эрхлэн явууллаа.

Хүний эрхэд ээлтэй сургууль



Олон Улсын Эмнэлийн Интернэшил Байгууллагаас дэлхийн 14 орны 17 сургууль дээр хэрэгжүүлж байгаа “Хүний Эрхэд Ээлтэй Сургууль” төслийг Монгол Энэтхэгийн хамтарсан сургуультай хамтран хэрэгжүүлж байна. Уг төслийн зорилго нь НҮБ-ын Хүний Эрхийн Боловсролын Дэлхийн Хөтөлбөрийн ЕБС-ийн тогтолцоонд хүний эрхийг нэвтрүүлэх” зорилтыг хэрэгжүүлэх, сургуулийн бүхий л үйл ажиллагаа түвшинд хүний эрхийг дээдэлдэг болгох зорилготой.

Боловсрол нь “Хүний эрх, соёлын ялгаатай байдлыг хүндэтгэх үзлийг төлөвшүүлэх, харилцан ойлголцол, энхийг эрхэмлэх, эрэгтэй эмэгтэйчүүдийн эрх тэгш байдлыг хүндэтгэн нийгэмд хариуцлагатай амьдрахад бэлтгэх, байgal orчноо хайрлан хүндэтгэдэг болгоход

хүүхдийн хүндэтгэлийг хөгжүүлэх ёстой. Иймээс боловсролын чанаарын тухай асуудлыг хөндөхдөө хүний эрхийн зарчмуудын үүднээс хандах ёстой ба сургалтын агуулга, арга зүй, орчин, сургуулийн дотоод дүрэм, журам, сургуулийн орчин нь өөрөө хүний эрхийг хүндэтгэсэн, хамгаалсан байхыг шаарддаг.

- Хүний эрхийн соёлыг бий болгох буюу хүний эрхийг хүндэлдэг орчинтой, хүний эрхийг мэддэг, хүний эрхийг хамгаалахын төлөө зүтгэдэг сургуулийн хамт олонтой, хүний эрхийн төлөө үр нөлөөтэй ажиллаж чаддаг хүний эрхийн үнэ цэнийг ойлгож, чадваржсан, туршлагатай суралцагчидтай болгох юм.

Хамрах хүрээ

- Сургалтын хөтөлбөр: Сургалтын хөтөлбөрийн бүхий л хэсгүүд болон сургах үйл ажиллагаанд хүний эрхийг нэгтгэхийг зорисон энэхүү төсөл нь багшийн хөтөлбөр боловсруулах чадварыг хөгжүүлэх, хичээлийг шинэ агуулга, арга зүйгээр баяжуулах, сургалтын практикт тулгарч буй асуудлуудыг шийдвэрлэхэд чухал хувь нэмэр болж байна.
- Хичээлээс гадуурхи үйл ажиллагаа буюу сургуулийн орчин: Суралцагчид боловсролоор дамжуулан бүрэн дүүрэн хөгжихөд нь чадавхижуулахад
- Сургуулийн удирдлага/ оролцоо: сургуулийн шийдвэр гаргах үйл ажиллагаанд сургуульд хамаатай хүн бүр оролцсоноор сургуулийн амьдралд өөрсдийн үүргийг илүү ухамсарлана

- Багш-сургач, сургач-сургачийн хоорондын харилцаа: Итгэлцлэл, хүндэтгэл, хариуцлагатай байх соёлыг бий болгосноор Ил тод байдал, хариуцлага өндөржиж, багш сургач, эцэг эхийн харилцаа сайжирна.

Боловсролын салбараас “нэгж хичээлийн бэлтгэл үр өгөөжийг нэмэгдүүлэх” стратегийг сонгож, сургалт, хүмүүжлийн ажлын агуулга, арга зүйн уялдаа холбоог сайжруулах ажлыг эрчимжүүлэх зорилтыг дэвшигүүлээд байгаа өнөөгийн нөхцөлд сургуулийн менежмент, зохион байгуулалт, боловсролын харилцаанд оролцгчдын сэтгэлгээ, хандлагыг өөрчлөхөд нааштай үр дунд хүргэх нь дамжигүй.

Иймээс уг төсөл нь одоогийн ЕБС-уудын сургалтын практикт тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэх арга замыг эрэлхийлэх, сургачдыг нийгмийн амьдралд оролцох, ирээдүйн иргэн болж төлөвшүүлэхэд чиглүүлсэн хичээлээс гадуурхи сургачдын дунд зохиох ажлын агуулга, арга хэлбэрийг шинэчлэн, олон улсын туршлагаас суралцаж сургуулийг “Хүний Эрхэд Ээлтэй Сургууль” болгон хөгжүүлэхэд чухал хувь нэмэртэй болох нь харагдаж байна.



Багш бүр заадаг хичээлдээ хүний эрхийн үзэл санааг тусгах нь хүүхдэд илүү ойлгомжтой, үр дүнтэй арга болохыг өөрсдөө туршиж мэдрэв. Багш нарын үр чадварын уралдаанаас.



Хүний эрхийн асуудлуудыг нэгтгэсэн хичээл бүхэн сургчдад сонирхолтой байлаа.



Хүний эрхийг хичээлүүдээр нэгтгэх нь



Ангид мөрдэх дүрмээ хүүхдүүд өөрсдөө хэлэлцэж гаргахдаа хүүхдэд бүр идэвхитэй оролцлоо.



Ангид мөрдэх дүрмээ өөрсдөө хэлэлцэж гаргаж ирэв.



Сурагчид хүний эрхийн тухай илтгэл тавьж байгаа нь.



"Хүний Эрхэд Ээлтэй Сургууль" төслийн багтай хамт Лондонд.



"ХЭЭС" төслийн анхны жилийн ажлын төлөвлөгөөнд багш бүрийн санаа оноо чухал байлаа.



Эцэг эрхийн оролцоо

Хүний эрхийн сургагч багш

Монголын Эмнэсти Интернэшнлээс 2009 онд Хүний эрхийн боловсролыг бусдад түгээх, чадварлаг, мэргэжлийн, хүний эрхийн сургагч багш нарыг бэлтгэх зорилгоор гишүүдийн дунд сургалт явууллаа. Тус хүний эрхийн сургагч багш бэлтгэх сургалтад нийт 21 хүн оролцсон юм. Тус сургалтын хүрээнд бэлтгэгдсэн сургагч багш нар бие даасан сургалтыг явуулж, олсон туршлагаа баталгаажуулсан бөгөөд хүний эрхийн сургагч багшийн сертификат хүлээн авсан юм.

◆ Сургагч багш Эрдэнэбулаг, Нямсүрэн, Хатантуул, Дүүриймаа нар БЗД-ийн 8-р хорооны

иргэдэд "Эрүүл мэнд ба Хүний эрх" сэдвээр сургалт явууллаа. Тус сургалтын хүрээнд эрүүл мэндийн болон хүний эрхийн мэдлэгийн үндсийг сургалтаар олгож, өөрийн эрхээ хамгаалж, эрүүл мэндийн тэгш, хүртээмжтэй, чанартай тусламж авах боломжийг бий болгох талаар заасан байна.

- ◆ Сургагч багш Пүрэвбаатар, Наранцэцэг, Мөнхчимэг нар СБД-ийн 9 дүгээр хорооны ажилчид, 4 дүгээр сургуулийн багш нарт "Эмэгтэйчүүдийн эрх, Хүүхдийн эрх-Хүний наймаа" сэдвээр нийт 21 хүнд сургалт явуулсан. Сургалтын үеэр хүний эрх гэж юу болох, түүний зарчмууд болон эрхээ хэрхэн эдлэх, хамгаалах асуудлыг дэвшүүлэн ярилцсан байна. Мөн ХЭТТ, "Охидын төлөөх аюулгүй сургууль" хөтөлбөрийн талаар мэдээлэл өгчээ.
- ◆ Дархан-Өргөө мэргэжил сургалтын төвд Эмнэсти Интернэшнлийн гишүүн Г.Ууганбаяр хичээл заасан юм. Нийгмийн багш Б. Одбаяр дэмжиж ажиллаа. Эмнэсти Интернэшнлийг Дархан хотын залуу үе болох оюутнуудад таниулж, залуу дэмжигчдийн хүрээг өргөжүүлж шинэ гишүүн нэмэх зорилгоор зохион явуулсан бөгөөд тэрчлэн оюутнуудад хүний эрхийн үндсэн ойлголт өгөх, эрх болон үүргийн тухай мэдүүлэх, Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглалыг амьдралд ямар чухал хэрэгтэйг нь ойлгуулахад оршиж байв.
- ◆ Нийслэлийн ЧД-ийн 10 дугаар хорооны иргэдэд "Зохистой орон байраар хангагдах эрх"-ийн тухай сургалтыг Оюутны бүлгийн гишүүн Мөнх-Эрдэнэ, Тэгшзаяа нар зохион явуулсан байна. Шаардлагад нийцэн орон байраар хангагдах нь хүний эрхийн чухал асуудал бөгөөд иргэд тодорхой мэдээлэл авч чаддаггүй, хүний эрхийн зөрчилд ихээхэн өртөж байдаг бөгөөд, энэхүү зөрчигдэх буй эрхийнх нь талаар ойлголт өгсөн юм. Сургалтад нийт 20 хүн оролцсон бөгөөд Хүний эрхийн сургалтын дараа өөрсдийн эрх нь хэрхэн зөрчигдэж байгаа талаар өгүүлж байсан юм. Тэд дахин энэ төрлийн сургалтад хамрагдах хүсэлтэй байгаагаа илэрхийлсэн байна.

Хүний эрхийн эдгээр сургалтуудаар иргэдэд хүний эрхээ мэдэх, эдлэх боломжоо хэрхэн хамгаалах талаархи мэдлэг олгох болон хүний эрх зөрчигдхөөс сэргийлэх ур чадварт сургах, эрхээ эрхэмлэх хандлагыг төлөвшүүлэхэд чиглэсэн байна.



Мөн хүний эрхийн онолын эрхийг бататгаж, эрхээс эдлэхэд асуудлыг хуулийн эрх зүйн онол, олон улсын үзэл баримтлалын үндсэн дээр тайлбарлах, олон улсын практиктай танилцуулахад чиглэгдсэн юм.



Хамтын ажиллагаа

БСШУЯ-тай хамтран хүний эрхийн үндэсний сургагч багш нар бэлтгэх сургалтыг зохион байгуулж явуулсаны үрээр энэ онд хөдөө орон нутагт хүний эрхийн сургалт, ялангуяа ЕБС-ийн хичээлийг хүний эрхийн асуудалдуулсан хэрхэн зохион байгуулах талаар тодорхой хөтөлбөр гарган ажиллаж байгаа юм. “Иргэний боловсрол хичээлээр хүний эрхийн ойлголтыг төлөвшүүлэх нь”, “Сургуулийг хүүхдэд ээлтэй болгоход сурган хүмүүжүүлэх харилцааны үүрэг” сургалтуудаар чанартай боловсролын төлөөх багш сурган хүмүүжүүлэгчдийн цаашдын үйл ажиллагаанд нь зохих хувь нэмрээ оруулах

зорилгоор энэхүү сургалтууд явагдах юм. Сургалтад МУИС-ийн химиин тэнхимийн багш Оюунцэцэг, Биологийн тэнхимийн багш Б.Батцэцэг, Нийслэлийн 1 дүгээр сургуулийн дүрслэх урлагийн багш Энхболд, багш Олоннэмэх, Тунгалаг-Оюун, Сайнбилэг, Цэрэнхам, Нажидмаа нар оролцон ажиллаж байна.



Бусад байгууллагуудын урилгаар зохион байгуулсан сургалт

Монголын Эмнести Интернешнлээс Алтайн худэр уул уурхайн компани, Улаанбаатар хотын мал эмнэлэгийн газар, Нийслэлийн 100 гаруй өрхийн эмнэлэгийн эмч нар, Татварын ерөнхий газар, Улсын нийгмийн даатгалын газар зэрэг байгууллагуудын хүсэлтээр хүний эрхийн талаархи холбогдох сургалтуудын зохион явууллаа. Тухайлбал “Алтайн худэр” компанийд “Уул уурхайн хариуцлага-Хүний эрх”-ийн асуудлаар явуулсан сургалтыг нийт 20 орчим хүнд явуулсан юм. Тус сургалтын агуулга “Хүний эрхийн хувьд компаний хариуцлага ямар байх ёстой вэ?” гэсэн асуудлыг дэвшиүүлж энэ талаар тайлбаруудыг өгсөн юм. Энэ үеэр удирдлагын зарим шийдвэрүүд өөрсдийн ажилчдын нөхцөл байдалд нийцдэггүй, нийгмийн асуудалд анхаарал төдийлэн тавьдаггүй, тэрчлэн ажилчдын нийгмийн асуудалд гадны компанийудын үйл ажиллагаа сөрөгөөр нөлөөлдөг талаар асуулт тавьж байсан юм. Сургалтын явцад хүний эрхийн зөрчил нь нийгмийн хариуцлага сүл байгааг илтгэнэ гэдгийг ойлгуулсан гэж үзсэн.

Орчин үед уул уурхан компаниудыг хариуцлагын асуудал ихээхэн чухал төдийгүй компаниуд энэтэл дээр хүний эрхийн мэдлэг хомс байгаагаа дурдаж байсан юм. Сургалтад хамрагдагсад тус сургалтыг шинэ мэдээлэл өгсөн ач холбогдолтой байсан гэдгийг илэрхийлэхийн сацуу илүү өргөн мэдээллийг хангалттай цагаар авахыг хүсч байгаагаа хэлсэн юм. Мөн Эмнести Интернэшнл байгууллагатай хамтран ажиллаж сонирхолтой байгаагаа илэрхийллээ.

Хүний эрхийн боловсролын "Белинда" тэтгэлэг

Английн Эмнести Интернэшнлийн гишүүн, хүний эрхийн эрхэм үйлстэн Белинда 2002 онд Монголын Эмнести Интернэшнлд ирж хамтран ажиллах хугацаандaa хүний эрхийн боловсролын үйл ажиллагаанд өндөр хувь нэмэр оруулсан юм. Тэрээр хүний эрхийн сургагч нарыг бэлтгэн чадавхижуулж, тодорхой байгууллагуудад сургалт явуулах, мөн хүний эрхийн номын санг гарвижуулах зэрэг олон зүйлийг хийж өгсөн юм.

Монголын Эмнести Интернэшнл болон Монгол улсад оруулсан хувь нэмрийг нь үнэлж, Монголын Эмнести Интернэшнл байгууллагад түүний гэрээслэн үлдээсэн хөрөнгөөр "Белинда сан" байгуулан, Хүний эрхийн залуу сургагч наарт зориулсан тэтгэлэг зарлалаа.

Энэ тэтгэлэг нь Монгол Улсад хүний эрхийн боловсролыг түгээн дэлгэрүүлэхэд хувь нэмэр оруулах, Монголын Эмнести Интернэшнлийн гишүүн залуучуудыг идэвхижүүлэх, залуу чадварлаг боловсон хүчнийг дэмжих, Монгол Улсад хүний эрхийн боловсролыг хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр түгээхийг дэмжих зорилготой юм.

Хүмүүст эрхийг нь ойлгуулах, эрхийнхээ төлөө тэмцэх санаа төрүүлэх зорилгоор ажиллаж буй залуу сургагч багш наарт энэхүү тэтгэлэг хувь нэмэр болно гэж Монголын Эмнести Интернэшнл үзэж байна.

Хүний эрхийн боловсролын стратеги төлөвлөгөөний үнэлгээ

Хүний эрхийн боловсролын үүрэг ач холбогдол үлэмж бөгөөд МЭИ нь өөрийн үйл ажиллагаа стратеги төлөвлөгөөнд хүний эрхийн боловсролын асуудлыг тусган үйл ажиллагаа явуулсан байна. Ингэснээр хүний эрхийг зөрчих явдлыг цаашид таслан зогсоох үйл хэрэгт хувь нэмэр болоод зогсохгүй томоохон хөрөнгө оруулалт болно гэж үздэг.

МЭИ-ийн 2004-2008 оны үйл ажиллагаатай танилцаж түүний үр дүнг тодорхойлон нэгтгэх улмаар цаашид анхаарах зүйлс, төлөвлөгөөнд тусгах шинэ санааг гаргах зорилготойгоор үнэлгээний ажлыг явууллаа.

Үнэлгээний багт сэтгэл зүйч, Докторант Д.Оюунномин, социологич, Хүүхдийн халамжийн

төвийн нийгмийн ажилтан Д.Нарантуяа, Эрхэм-Үүд сэтгэл зүйн төвийн сэтгэл зүйч Ц.Эрхэмбат, Боловсрол дээд сургуулийн багш Б.Балццэг нар ажиллалаа.

Үнэлгээний багийн зүгээс ажиглалт, фокус бүлгийн уулзалт, судалгаа, тайлан бичиг баримттай танилцаж дүгнэлт гаргасан юм. Үүнд: Хүний эрхийн сургагч багшаар бэлтгэгдсэн багш нарыг бүртгэж бэлдсэн сэдэв, сургалт явуулах нөөц зэргийг багтаасан мэдээлэл бүхий сүлжээнд оруулах, Сургалтын үйл явцын хугацааг нарийн тогтоож төлөвлөгөөт хугацааг гаргах, сургалтын үр дүнг тухайн байгууллага өөрсдийн үйл ажиллагаанд хэрхэн авч ашигласан, цаашид өөрчлөх, нэмэгдүүлэх зүйлсийг гаргах эргэх холбоог сайжруулж, хяналтын тогтолцоог бүрдүүлэх, технологийн дэвшилийг ашиглан зайн сургалтуудыг зохион байгуулах, хүний эрхийн талаархи радио хэллэлцүүлэг хичээл явуулж, мэдээллийг авч болох цэгүүдийг нээх, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог дээшлүүлэх тэдний эрхийг таниулах үйл ажиллагааг явуулах, асрамжийн газар, халамжийн төвүүдэд хүрч ажиллах нөхцлийг судлах, зарим нэгэн төрийн албанад хандсан төсөлт үйл ажлуудыг олон нийтийн мэдээллийн хэрэгслийдийг ашиглан нийтэд мэдэгдэх замаар нийгмийн хяналтад байлгах зэрэг санал, зөвлөмжийг боловсруулсан байна.



ЗАЛУУЧУУД

Өнөөдөр Монгол улсын хүн амын 70 орчим хувийг хүүхэд залуучууд эзэлж байгаа бөгөөд тэднийг олон улсын болоод орон нутгийн хүрээнд хүний эрхийг хамгаалах ариун үйлсэд татан оролцуулахын тулд МЭИ ажилласаар ирсэн билээ. Залуучууд гэдэг бүх зүйлд сэтгэлээсээ хандаг тэр тусмаа хүний эрхийг хамгаалах үйлст онцгой хувь нэмрийг оруулж чадах нийгмийн томоохон хүчтэй бүлэг юм.

Залуучуудын сургалт

Залуучуудын бүлгийн гишүүд МОНФЕМНЭТ төрийн бус байгууллага, Хөгжицгөө клубтай хамтран "Эрхийн төлөө гаралт өргөцгөө" аяны хүрээнд хүний эрх, хүний эрхийн түгээмэл тунхаглал, жендэрийн тухай ойлголт, кампанит ажил, стратеги төлөвлөгөө, бүтээлч кампанит ажил явуулах "Үе тэнгийнхэн" сургалтыг зохион байгуулсан МЭИ-ийн 30 гаруй залуучууд хамрагдлаа. Сургалтаар хүний эрхийн хичээлийг заахдаа хүний эрхийн сургагч багш нараас гадна залуучууд өөрсдөө судалгаа хийж, зааж зохион байгуулсан нь хүний эрхийн идэвхитэн, манлайлاغч бэлтгэх ач холбогдолтой боллоо. Сайн дурын ажилтан Жэймс Адамс "Залуу манлайлагч" бэлтгэх сургалтыг явуулж залуучуудыг идэвхижүүллээ. Сургалтын үрдүнд МЭИ-ийн Оюутан залуучуудын бүлгийн гишүүд, Хөгжицгөө клуб, Гэрэгэ клуб, бусад хүний эрхийн байгууллагуудын залуу ажилтнууд цаашид хамтран хүний эрхийн төлөө олон үйл ажиллагааг үргэлжлүүлэн хийхээр төлөвлөж өөрсдийн салбар хүрээнд хүний эрхийн соёлыг түгээхийн төлөө ажиллаж байна.

Сайн дурынхан

МЭИ-ийн гишүүд жилээс жилд кампанит ажилд идэвхитэй оролцохос гадна байгууллагын өдөр тутмын үйл ажиллагаа, сургалт, сурталчилгаа зохион байгуулахад сайн дураараа цаг хугацаа, эрдэм мэдлэгээ хандивлан идэвхитэй оролцсоор, чадважихсаар, өргөжсөөр байна. "МЭИ-ийн Сайн дурын ажилтнуудыг ажиллуулах журам"-ын дагуу 33 гишүүн гэрээ байгуулан, ажлын хуваарь, үйл ажиллагааны чиглэл, төлөвлөгөө гарган Хүний Эрхийн Боловсрол, Цаазаар авах Ялын болон Эрүүдэн шүүхийн эсрэг, Залуучууд, "Хүний Хүндэл" зэрэг кампанит ажлуудад ажиллав. МЭИ-ийн сайн дурынхан Сайн дурын байгууллагуудын Чуулга уулзалтанд 2 сар тутамд оролцохын зэрэгцээ тус сүлжээтэй хамтран "Улс Ардын Их Хувьсгалын 88 жил"-ийн ойн их баяр

наадмын үеэр Наадмын талбайд ажиллаж ЭИ-ийг сурталчилж, хүний эрхийн талаар танилцуулга хийлээ.

2009 оны 8 дугаар сард МЭИ Сайн дурын ажилтнуудаа үнэлэх "Сайн дурынхны амралт-өдөрлөг"-ийг зохион байгуулж, шилдэг сайн 10 хүнийг тодрууллаа.

Олон улсын сайн дурынхны өдрөөр МЭИ-ийн сайн дурын ажилтнуудын уулзалт өдөрлөгийг зохион байгуулж амжилт оноо, алдаа дутагдлаа дүгнэн хэлэлцэж, цаашид хэрхэн үр бүтээлтэй ажиллаж болох вэ сэдвээр хэлэлцүүлэг хийлээ. Олон Улсын Тэгш эрхийн өдрийг тохиолдуулан Ази Номхон Далайн Бүсийн Залуучуудын Сүлжээнээс зохион байгуулсан "Хүний Хүндэл" кампанит ажлын хүрээнд сайн дурын ажилтан М.Буянхишиг, Б.Цолмон, Т.Мөнхсүурь, Б.Ган-Эрдэнэ нар "Чи өөрөө гэрэл" дууг дуулж, дүрс бичлэг хийж илгээлээ.

Сайн дурын гишүүд маань өөрсдийн үйл ажиллагааг зохион байгуулалттай болгох, үр дүнтэй ажиллах үүднээс чадавхи бэхжүүлэх 10 гаруй сургалтыг зохион байгуулав.

Цэмцгэр Монгол наадам

7 дугаар сарын 11-12-нд Монголын сайн дурын сүлжээний байгууллагаас зохион байгуулсан "Цэмцгэр Монгол наадам" фестивальд Я.Мөнхчимэг, М.Наранзаяа, Л.Дашням, Х.Минжин, сурагчдын бүлгээс Б.Номин, чөлөөт бүлгээс Э.Хуягцэцгээ, Б.Мягмарсүрэн, сайн дурын ажилтан Кристина Жосс нар оролцож, ажиллалаа. Уг наадам нь сайн дурынхны ажил үйлсийг сурталчлах, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд туслах аян зохион байгуулах зорилготой байсан юм.

Гишүүд маань Эмнеести Интернэшнлийн тараах материал, гарын авлагыг олон нийтэд түгээсэн. "Эрхээ эдэлбэл шоколад шиг амтагдана" хэмээх асуулт хариултын тэмцээнийг монгол, англи хэл дээр явуулж, асуултанд зөв хариулсан хүмүүст шоколад өгч байсан нь хүмүүсийн анхаарлыг татсан сонирхолтой арга хэмжээ болсон билээ.

Залуучуудын үйл ажиллагааны үнэлгээ

2009 оны 4 дүгээр сард Олон Улсын Хөгжлийн Баг ирж Залуучуудын төслийн үнэлгээ хийлээ. Тэд МЭИ-ийн Удирдах болон Хяналтын Зөвлөлийн гишүүд, Гүйцэтгэх Товчооны ажилтнууд, Үнэлгээний багийн гишүүд, Залуучуудын болон бусад бүлгийн гишүүд мөн Дархан бүлгийн нийт 100 гаруй хүнтэй уулзаж ярилцлаа. Ярилцлагаас МЭИ-ийн залуучуудын бүлгийн Хүний эрхийн үйлсэд оруулж буй хувь нэмрийг сайн үнэллээ. Түүнчлэн дэлхийн бусад орны залуучуудад тохиолддог бэрхшээл саад бүхэн

манайханд бас ижил байгааг онцлон тэмдэглэээ.

- Гишүүдээ хадгалж үлдэх бодлого боловсруулах
- Залуучуудын болон бусад бүлгийн гишүүдээ үйл ажиллагаанд хамруулах төлөвлөгөө гаргах
- Гишүүд идэвхитэнүүдтэй идэвхитэй харилцах аргyg боловсруулах
- Залуучуудын болон бусад бүлгийн гишүүдээ хүний эрхийн сургалтыг системтэйгээр хийх төлөвлөгөө гаргах
- Цахим харилцаагаа сайжруулж, бусад төрлийн харилцааны хэлбэрүүдийг түлхүү ашигладаг болох
- Бусад ТББ-тай хэрхэн хамтран ажиллах талаар төлөвлөгөө боловсруулах зэрэг зөвлөмжүүдийг гаргалаа.

Залуучуудын "Эрх Чөлөөний Парад" 2 дахь удаагаа амжилттай болж өнгөрсөн ба Сайн дурын ажилтан Жеймс Адамс, Залуучуудыг хариуцсан УЗ-ийн гишүүн Д.Оюунномин болон Залуучуудын бүлгийн гишүүд оролцон үнэлгээ хийж, амжилт дутагдал, алдаа оноогоо ярилцан, цаашид анхаарч ажиллах зөвлөмж гаргалаа.

Эрх чөлөөний парад

Хүүхэд залууст хүний эрх, эрх чөлөөний мэдрэмжээ дээшлүүлэн, хүний эрх, эрх чөлөөг сонирхолтой, бүтээлч, хөгжилтэй хэлбэрээр олон нийтэд сурталчлан, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх зорилгоор Монголын Эмнести Интернэшнл, МОНФЕМНЭТ, Хөгжицгөө клубын төлөөлөгч, залуучууд хамтарч 2009 оны 9 дүгээр сарын 12-ны өдөр "Эрх чөлөөний парад өдөрлөг"-ийг зохион байгуулав.

Эл өдөрлөг "Эрхийнхээ төлөө гарaa өргөцгөө" залуусын аяны хүрээнд болж өнгөрлөө. З байгууллагын нийт 40 залууст хүний эрхийн боловсрол олгох үе тэнгийнхний сургалтыг хийсэн ба сургалтаа залуус өөрсдөө оролцооны, хөгжилтэй, нээлттэй байдлаар явууллаа. Парадаар "Хүнийг Хүндэл", "Цаазаар авах, эрүүдэн шүүхийг эсрэг", "Эмэгтэйчүүдийн хүчирхийллийн эсрэг" кампанит ажил болон үүний хүрээнд "Охидод аюулгүй сургууль" зэрэг кампанит ажлуудын үйл ажиллагааг олон нийтэд таниулсан билээ.

Ойролцоогоор 1000 гаруй хүн парадын үйл



ажиллагаанд хамрагдсан ба кампанит ажлуудтай танилцан, захидал уриалгад гарын үсэг зурлаа. Парадын үеэр Залуусын аяныг дэмжих, МЭИ-ийн Урлагийн бүлгийн гишүүн Куйза, ВХ, Тэнүүн, Агиймаа, "Лимонс" хамтлаг зэрэг урлагийн одод ирж ая дуугаа өргөн, "Хүний эрх загварын шоу" үзүүлбэрээр загвар өмсөгч охид, хөвгүүд ЭИ-ийн хүний эрхийн мессэжийг бичсэн богино цамцыг өмсөн тайzan дээр гарч ирсэн нь манайдаа шинэд тооцогдох үзүүлбэр болж олны анхаарлыг татлаа.

Хамтын ажиллагаа

Залуучуудын бүлгийн ахлагч М.Буянхишиг, Урлагийн бүлгийн гишүүн Б.Батцэнгэл нар Ази Номхон Далайн Бүсийн Залуучуудын Сүлжээнээс "ХүнийгХүндэл" кампанитажлынэлчээрсонгогдсон ажиллаж мөн Гонконг улсад болсон бүсийн уулзалтанд 2009 оны 9 дүгээр сард амжилттай оролцлоо. Тэд "Хүнийг Хүндэл" кампанит ажлын хүрээнд үйл ажиллагаагаа чиглүүлж явууллаа. Залуучуудын бүлэг АНДБЗ-ын онлайн сүлжээнд нэгдэн туршлага, үзэл бодлоо хуваалцаж мөн блог ажиллуулж байна.

Мөн Залуучуудын бүлгийн гишүүн М.Буянхишиг, Лхагвасүх нар 2008 оны Эрх Чөлөөний Парадын үеэрий "Зэвсгийг хянаа" кампанит ажилд зориулан хийсэн "бөмбөлгөн танк"-ны зурагтайгаа ЭИ-ийн "The Wire" сэтгүүлд гарлаа.

Залуучуудын бүлгийн ахлагч М.Гэрэлмаа Норвеги улсад 2009 онд зохион байгуулагдсан "Оюутан залуусын фестиваль"-д амжилттай оролцлоо. Түүнчлэн тэрээр Оюутны бүлгийн гишүүн Б.Энхбаярын хамт Английн Сайн Дурын байгууллагаас зохион байгуулдаг "Сайн дурынхны туршлагаас солилцох" хөтөлбөрт шалгарч Англи улсад 3 сар, Монгол улсад 3 сар ажиллаад ирлээ. Оюутны бүлгийн гишүүн Б.Энхбаяр Английн Сайн Дурын байгууллагаас зохион байгуулдаг "Сайн дурынхны туршлагаас солилцох" хөтөлбөрт хамрагдаж, Дорнод аймгийн Чойбалсан хотод ажиллах байх хугацаандaa Чойбалсан хотын "Хүүхдийн төлөө төв"-тэй хамтран Үе тэнгийнхний сургалт болон Хүний эрхийн театрын сургалт хийж 22 "Эрхүүлэй" багш бэлдсэн байна.



БАЙГУУЛЛАГЫН ӨСӨЛТ ХӨГЖИЛТ

Гишүүнчлэл, бүлгийн байдал

Монголын Эмнеси Интернэшнл байгууллага 2009 оны 11 дугаар сарын 1-ний байдлаар нийт 1300 гаруй бүртгэлтэй гишүүнтэй байна. Үүнээс татвар төлсөн нь 290 гишүүн байна. Гишүүд нь Багш нарын, Залуучуудын, Оюутны, Сурагчдын, Эрэгтэйчүүдийн, Эмэгтэйчүүдийн, Сэтгүүлчдийн, Хуульчдын, Чөлөөт, Үйлдвэрчний Эвлэлийн, Урлагийн, Эмч нарын, Багануурын, Дарханы, Эрдэнэтийн гэсэн 15 бүлэгт хуваагдаж байна. Парламентийн болон Яаралтай үйл ажиллагааны гэсэн албан ёсны бүлгүүд байна.

Гишүүдийн улирлын уулзалт

Гишүүдийн улирлын уулзалт нь байгууллага болон бүлгийн үйл ажиллагааг үнэлэх, төлөвлөх, тайлagnaх, шинэ бодлого, чиглэлийг таниулах, дотоод ардчиллыг бэхжүүлэхэд гишүүд, бүлгийн үйл ажиллагааг тогтмолжуулах зорилготой юм. Улирлын уулзaltaар сургалт, сан аввижуулах болон идэвхи санаачлагыг өрнүүлэх үйл ажиллагаа явулахаас гадна гишүүдээ өөр хоорондоо танилцан туршлага судлах боломжийг олгодог юм.

Нэгдүгээр улирлын уулзалт:

2009 оны 2 дугаар сарын 7-ны өдөр Улаанбаатар хотын хойно 25 км-ийн цаана орших Согоотод амралт ажлыг хослуулан хийлээ. 2006-2010 оны хооронд хэрэгжүүлэх “Залуучуудын Стратеги Төлөвлөгөө”-ний талаар гишүүддээ мэдээлэл хийж, ахмад гишүүд болон залуу үеийг дотносуулах, багаар тоглох хөл бөмбөг, гар бөмбөгийн тэмцээн явууллаа. “Цэвэр агаарт” нэртэй тус уулзaltaар 2009 онд хийх үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу тусын бүлэгтэй нарийвчилсан төлөвлөгөөг хэлэлцэв. МЭИ-ийн спортын шилжин явах цомыг энэ удаагийн уулзalтаас эхлэн олгох болсон ба М.Буянхишиг ахлагчтай баг хөл бөмбөгийн тэмцээнд түрүүлэн цомыг гардаж аван дараагийн уралдаан тэмцээн болтол хадгалах боллоо.

Хоёрдугаар улирлын уулзалт:

Пума зочид будлын хурлын танхимд 2009 оны 6 дугаар сарын 19-ны өдөр боллоо. “Хүнийг Хүндэл” кампанит ажлын талаар танилцуулж, МЭИ 2010-11 онд юу хийх вэ гэсэн хэлэлцүүлэг өрнүүлж үйл ажиллагааны төлөвлөгөөнд оруулах санал авлаа. Хуульчдын бүлгийн гишүүн, уран илтгэгч С.Эрдэнэболд гишүүдэд “Зүлгэн дээр гэрээ бариад зүгээр нэг амьдарч болохгүйн учир” нэртэй лекц

уншлаа. Энэ үеэр Хүний эрхийн сургагч багшийн сургалтанд сууж, дадлагаа амжилттай хийсэн сургагч багш нарт Сертификат гардуулав.

Гишүүдэд зориулсан сургалт

Гишүүд дэмжигчдийн хүний эрхийн боловсрол нэмэгдэхийн хэрээр үйл ажиллагаа чадавхижисаар байна.

Шинэ гишүүдийн сургалт

Байгууллагаас зохион байгуулж байгаа сургалт, уулзалтын үеэр ЭИ-ийн хийсэн танилцуулга, олон нийтийг хамарсан кампанит ажил болон бусад үйл ажиллагааны үр дүнд гишүүд шинээр элсэж, элссэн гишүүдийн 60% нь шинэ гишүүдийн сургалтанд хамрагдлаа. Шинэ гишүүдийн сургалтаар ЭИ-ийн үүсэл, Хүний эрхийн талаар ярилцлага хийж, МЭИ-ийн гол кампанит ажлуудыг танилцуулахын зэрэгцээ Өөрийн оронд ажиллах дүрэм, түүний ач холбогдол, МЭИ-ийн бүтэц, зохион байгуулалт, Удирдах болон Хяналтын Зөвлөл, тэдний үүрэг хариуцлагын талаар танилцуулдаг юм.

Хүний эрхийн сургалт

Эрүү шүүлт, Цаазаар авах ял, Эдийн засаг, нийгэм, соёлын эрх, ХЭТТ, Эмэгтэйчүүдийн эрх болон “Хүнийг Хүндэл” кампанит ажилтай холбоотой сургалтыг 2009 онд гишүүддээ зориулан явууллаа. Сургалтыг Оюутан, Залуучуудын бүлгийн гишүүд мөн кампанит ажлын зохицуулагчид удирдаж Эрдэнэт, Дархан, Багануур зэрэг хөдөө орон нутгийн бүлгийн гишүүд оролцлоо. 2009 онд Эмэгтэйчүүдийн бүлэг хоёр удаа, ҮЭ-ийн болон Чөлөөт бүлгүүд тус бүр нэг удаа сонгосон сардаа Хүний эрхтэй холбоотой сэдвээр гишүүддээ чадавхи бэхжүүлэх сургалт зохион байгууллаа.

Английн сайн дурын нийгэмлэгийн сайн дурын ажилтан Нина Коули хэрхэн хүний эрхийн асуудлаар мэтгэлцэх, яаралтай үйл ажиллагаанд хариу өгэх талаар цуврал сургалтыг Залуучуудын бүлгийн гишүүдэд хийлээ.

Бүлгийн ахлагч нарын манлайллын талаархি сургалт

Бүлгийн ахлагч нарын чадавхи, манлайллыг сайжруулах зорилгоор эл сургалтыг зохион байгуулав. Манлайлдчийн үүрэг хариуцлага, Кампанит ажлын төлөвлөгөө, сан аввижуулалт, хурал хэрхэн зохион байгуулах, хэвлэл мэдээлэлд хэрхэн хандах, илтгэх, ятгах урлагийн тухай мэдлэг, чадавхиа сайжруулаа.

Бүлгийн уулзалт, үйл ажиллагаа

2009 оныг бүлгийн идэвхитэй оролцооны жил болгон зарласантай холбоотой бүлэг бүр хурал, уулзaltaа зохион байгуулж байлаа. Залуучуудын бүлэг 10 гаруй бусад бүлгүүд 3-5 удаа бүлгийн хурлаа хийж, хийх ажлаа төлөвлөж, хэлэлцэн нь гишүүдийг идэвхижүүлж, үйл ажиллагаанд илүү татан оролцуулж байлаа. ОУХБ-ийн уулзалт, Бүх гишүүдийн улирлын уулзалтууд, "Хүнийг хүндэл" кампанит ажлын сургалтууд мөн ОУЗХ-ын хэлэлцүүлэгт гишүүд бүлгүүд идэвхитэй оролцлоо. 2009 онд бүлгийн үйл ажиллагаа, гишүүдийг идэвхижүүлэхзорилгоор бичилтөслийг хэрэгжүүлэх ажлыг Эмэгтэйчүүдийн, Эрэгтэйчүүдийн, Эмч нарын, Хуульчдын, Сэтгүүлчдийн, Дархан, Эрдэнэтийн, Багш нарын болон Оюутны бүлгүүд хийлээ. Тэд олон нийтэд хүний эрхийн талаар сургалт, сурталчилгаа хийн, сангаа арвижуулсан байна. Эдгээр нь гишүүдийн мэдлэг чадварыг нэмэхийн зэрэгцээ тэднийг хооронд нь танилцуулсан ажил боллоо.

Орон нутаг дахь бүлгийн үйл ажиллагаа

Дархан, Эрдэнэтийн бүлэг орон нутагтаа МЭИ-ийн кампанит ажлын болон хүний эрхийн талаархи мэдээллийг хүргэн, Бирмийн төлөө үйл ажиллагаанд нэгдэн, 100 ил захидалд гарын үсэг зурлаа. Дархан бүлэг Залуучуудын төслийн үнэлгээний багийг орон нутагтаа хүлээн авч халуун дотно яриа өрнүүлж, үйл ажиллагаагаа танилцууллаа.

Багануур бүлгийн үйл ажиллагаа нэлээд хожуу "Хүнийг Хүндэл" кампанит ажлын сургалтанд хамрагдсанаар эхэллээ. Тэд Кени улс дахь хүчээр нүүлгэн шилжүүлэлт болон Съерра Лион дахь эхийн эндэгдлийг бууруулах талаар захидал уриалгад гарын үсэг зурлаа.

Дархан бүлгийн ахлагч Ууганбаяр, Эрдэнэт бүлгийн ахлагч багш С.Хажидмаа, Батчимэг нар Хүний эрхийн хамгаалагч нарт зориулсан "Хүний эрхийн сургагч багш"-ийн сургалтанд хамрагдаж, орон нутагтаа туршилтын хичээлээ амжилттай зааж, Бүх Гишүүдийн Уулзaltaараа Сертификатаа гардан



авлаа. Дархан, Эрдэнэтийн бүлэг Олон Улсын Хүний эрхийн өдрөөр Хүний эрхийн аян зохион байгуулж, хүний эрхийн ухамсар төлөвшүүлэх, ХЭТТ-ыг сурталчлах, эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор сургач хүүхдүүд болон сургагч багш нарын дунд сургалт, уралдаан зохиож, сангаа арвижууллаа.



Сан арвижуулалт

-Сан арвижуулах хорооны үйл ажиллагаа

МЭИ нь сан арвижуулах стратеги төлөвлөгөөг 2007 онд боловсруулан хэрэгжүүлж байгаа бөгөөд үүнийг хэрэгжүүлэхэд сан арвижуулах хороог байгуулан ажиллаж байгаа билээ. Сан арвижуулах хороо нь Гүйцэтгэх товчоо, Удирдах зөвлөл, бүлгийн ахлагч, бүлгийн гишүүдийн төлөөлөл бүхий гишүүдтэй бөгөөд стратеги төлөвлөгөөний дагуу байгууллагыг сурталчлах томоохон үйл ажиллагааг зохион байгуулах болон гишүүн бурийн сан арвижуулалт хийх ерөнхий төлөвлөгөөг гаргав. Сан арвижуулах хороо 2009 онд 3 удаа хуралдаж шийдвэрүүд гаргасан ч зарим нэг нь эдийн засгийн хямарлтай холбоотой биелэлт нь тааруу байна. МЭИ 2009 онд сан арвижуултын талаар нэлээд олон зүйлийг хийхээр төлөвлөсөн билээ. Улаанбаатар зочид буудалд ЭИ-ийн гишүүд төлөөлгчдийг хөнгөлөлттэй үнээр байрлуулж байна. ОУНБДНГ-ын Сан арвижуулах хөтөлбөрийн төслийн багтай харилцаатай байж сан арвижуулах талаар санал бодлоо тогтмол солилцож байна.

-Бүлэг, гишүүдийн сан арвижуулалт

2009 онд гишүүн бүр сан арвижуулалт хийх хүсэл эрмэлзэлтэй байлаа. Залуучуудын бүлгийн гишүүд "МЭИ-ийн Сүлд мод"-оор сан арвижууллаа. Гишүүдийн улирлын уулзалт, олон нийтэд зориулсан үйл ажиллагааны үеэр гишүүд сан арвижуулах хайрцгийг аялуулан, ЭИ-ийн логотой футболка, төрөл бурийн бараа, ном хэвлэлийг борлуулж байна.

Хэвлэлийн "Арвай принтинг" компани өөрийн хэвлэсэн бүтээгдхүүн бүрээс 1 төгрөгийг хандивлаж сан арвижуулж байна.

Төлөвлөлт, шийдвэр гаргалт, хариуцлага

Удирдах зөвлөлийн хурал

МЭИ-ийн удирдах зөвлөл нь ээлжит 6 хурал, ээлжит бус 5 хурлыг 2009 онд зохион байгуулж байгууллагын бодлого, төлөвлөгөө, тайланг хэлэлцэв. Энэ хугацаанд 21 шийдвэрийг гаргаж, 6 ажлын хэсгийг байгуулан ажиллав. ОУНБДНГ-аас ирсэн Үнэлгээний баг болон хүний эрхийн шинжээч нартай мөн ажлын уулзалт хийж, тайланг нь сонслоо. Хэвлэл мэдээллээр ЭИ-ийг сурталчлах, төлөөлөх, олон улсын болон үндэсний хэмжээнд зохиогдож буй хурал семинаруудад суух, санарвижуулах, кампанит ажлын нээлт, хаалтын үйл ажиллагаануудад УЗ-ийн гишүүд аль болох хүйсийн тэнцвэрт байдлыг хадгалан идэвхитэй оролцож хувь нэмрээ оруулж байна.

Гүйцэтгэх товчооны үйл ажиллагаа

Гүйцэтгэх товчоо нь долоо хоног тутам хуралдаж ажлын нарийвчилсан төлөвлөгөөг гарган түүний хэрэгжилт, амжилт дутагдлыг хэлэлцдэг. Гишүүд дэмжигчидтэйгээ ойр хамтран ажиллаж, өөрсдийн мэргэжлийн хүрээнд чадавхижих байгаагийн зэрэгцээ ОУНБДНГ-ын холбогдох баг, ажилнуудтай тогтмол харилцаатай ажиллаж байна.

Хяналтын зөвлөл

Хяналтын Зөвлөл нь З гишүүнтэйгээр үйл ажиллагаа явуулж, З удаа хуралдаж Удирдах зөвлөл болон Гүйцэтгэх товчооны ажилд хяналт тавьж ажилласан. Хяналтын Зөвлөлийн гишүүн бүр Удирдах зөвлөлийн хурлын шийдвэрийн дагуу ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж ажиллалаа. 9 үндсэн чиглэлээр 21 албан ёсны шийдвэрт дүгнэлт тавьж ажилласан.

Ерөнхий чуулган

МЭИ-ийн 14 дүгээр Ерөнхий Чуулган 12 дугаар сарын 17, 18-ны өдрүүдэд хуралдаж, 2009 онд хийсэн ажлынхаа тайланг тайлagnan, амжилт бүтээл алдаа оноогоо дүгнэсэн, ирэх ондоо хийх төлөвлөсөн ажлаа танилцуулсан чуулган болж өндөрлөлөө. Чуулганаар төлөөлөгчид “МЭИ-ийн дүрэм”-д оруулах өөрчлөлт, “МЭИ-ийн 2010-2012



оны үйл ажиллагааны төлөвлөгөө”-г хэлэлцэн баталлаа.

Чуулганд Монгол улсын Ерөнхийлөгчийн хүний эрхийн зөвлөх Ц.Оюунгэрэл уригдан оролцож “Монгол улс дахь хүний эрхийн нөхцөл байдлын чиг хандлага ирэх б жилд” сэдвээр сонирхолтой илтгэл тавилаа.

“Хүний эрхийн боловсрол номын сан”

МЭИ хүний эрхийн боловсролын номын санг 1998 оноос ажиллуулж байна. Үүнд хүний эрх, хүний эрхийн боловсрол, цаазаар авах ял, эрүү шүүлт, олон улсын хүний эрхийн гэрээ хэлэлцээрүүд, кампанит ажлын гарын авалага, төрийн бус байгууллагын удирдлага, эдийн засаг, нийгэм соёлын эрхийн талаарх ном хэвлэл, хүүхдийн эрх, эмэгтэйчүүдийн эрх, хүйсийн тэгш байдлын талаархи асуудал, дүрвэгчид, цагаачид, монголын хууль, эрх зүй, тогтоомжууд, ардчилал, цагдаа хорих байгууллагатай холбоотой 1300 гаруй ном товхимол байдаг. Номын сан их дээд сургуулиудын дунд байдаг бөгөөд уншигчиддаа үнэ төлбөргүй үйлчилдэг юм. Номын сан маань хувь хүмүүс, төрийн болон төрийн бус байгууллагуудын хандив, тусламжаар улам өргөжсөөр байна. 2009 онд семинар сургалтуудаас ном цуглуулж, ном худалдан авч, хандивын болон байгууллагаас гаргасан шинэ ном товхимол гарын авлагар номын сангаа баяжуулав. Нийтдээ 50 төрлийн 150 гаруй ном, долоо хоног тутмын мэдээллийн чанартай сэтгүүлүүд нэмэгдсэн байна. ҮЭ-ийн бүлэг, УЗ-ийн дарга Р.Янжмаа, Хуульчдын бүлгийн гишүүн А.Түвшинтулга, С.Эрдэнэболд, Ж.Амарсанаа нар нийт 100 гаруй төрлийн 1 сая орчим төгрөгийн ном хандивлав.



ОРОЛЦСОН ХУРАЛ, СЕМИНАР

Үндэсний хурал, семинар

Хурал зөвлөгөөн сургалт семинарын нэр	Хаана хэзээ хэн оролцсон	Гол асуудлууд
“Хоёр толгойн хөрөнгө оруулалтын гэрээ ба Монголын Иргэний Нийгмийн Байгууллага” зөвлөлдөх уулзалт	Улаанбаатар 1 сарын 10 Э.Отгончулуун	Оюу Толгой, Таван Толгойн тойрон үүсч буй эдийн засгийн, байgal орчны, улс төрийн асуудлууд дээр Иргэний Нийгмийн байр суурийн талаар
Иргэний нийгмийн хөгжлийг үнэлэх чуулган	Т.Ариунаа П.Мөнхжаргал 1 сарын 23 Улаанбаатар	Монголын иргэний нийгмийн хөгжлийн түвшин, цаашид анхаарах асуудлууд
Иргэний нийгмийн тогтвортой хөгжлийг хангах төрийн бодлого уулзалт	Б.Алтантуяа 1 сарын 26 Улаанбаатар	Иргэний нийгмийн хөгжлийг хангах төрийн болон засгийн газрын бодлого
Өмнөговь аймгийн нийгэм, эдийн засаг, байгаль орчны суурь судалгаа	Улаанбаатар 1 сарын 28 Э.Отгончулуун	Өмнөговь аймгийн нийгэм, эдийн засаг, байгаль орчны суурь судалгааны тайлагналт http://www.utmugovi.mn
Үндэсний сайн дурынхны чуулга уулзалт	Залуучуудын бүлэг Улаанбаатар, Монгол улс. 1-9 сар	Сайн дурын байгууллагын сүлжээний хийх ажил, төлөвлөгөө, цаашид хэрхэн туршлагаа хуваалцах талаар
ТЕГ, ТББ-үуд хамтран ажиллах арга зам-дугуй ширээний ярилцлага	Р.Янжмаа 1 сарын 30 Улаанбаатар	ТЕГ, ТББ-үуд хамтран ажиллах арга замын тухай
Онол практикийн бага хурал: Сэжигтэн яллагдагчийн цагдан хорих ажиллагаанд анхаарах зарим асуудлууд	Б.Алтантуяа Г.Амарзаяа 2 сарын 6 Улаанбаатар	НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцийн Нэмэлт Протоколд нэгдэн орохын ач холбогдол
АН-ын төв байр дээр 2008 оны 7 дугаар сарын 1-ний үймээн самуун	Улаанбаатар 2 сарын 11 Э.Отгончулуун	Хүрэлцэн ирсэн хувь хүмүүс мөн ТББ-ын төлөөлөл үймээн самуунтай холбоотой асуудлууд дээр саналаа солилцов
“ Эмэгтэйчүүдийн нүдээр”- IV Чуулган	Р.Янжмаа 3 сарын 6 Улаанбаатар	Хүүхэд хамгаалал ба Үндэсний аюулгүй байдлын талаар
Жендерийн тухай	П.Мөнхжаргал 3 сарын 18 Улаанбаатар	Жендерийн конструкц ба эрэгтэйлэг шинж, Монгол эрийн уламжлалт дур ба гей, Монголчуудын эрэгтэйлэг, эмэгтэйлэг шинжийн тухай ойлголтын хувьсал
ТББ-ын сургалт	Г.Амарзаяа 5 сарын 23 Улаанбаатар	Нийтээр дагаж мөрдүүлэх шийдвэрийн тухай ойлголт, олон нийтийн оролцоо
Олон нийтийг хэрхэн зохион байгуулах нь	П.Мөнхжаргал 6 сарын 24-25	Олон нийт гэж юу болох, олон нийтийг хэрхэн зохион байгуулах
Мини НҮБ-дугуй ширээний ярилцлага	Я.Мөнхчимэг 8 сарын 25 Улаанбаатар	Мянганы хөгжлийн зорилт ба Залуучуудын оролцоо, Өөрчлөлтийн үе дэх Залуучуудын талаар
Монгол дахь иргэний болон улс төрийн эрхийн хэрэгжилт, ТББ-үудын Үндэсний Чуулган	Б.Алтантуяа 11 сарын 7 Улаанбаатар	ТББ болон ТБ-үуд хамтарч ажиллах нь
НХҮГ-ын зөвлөлдөх уулзалт	Улаанбаатар 11 сарын 11 Э.Отгончулуун	Олон улсын болон ТББ-тай 2010 онд хамтран ажиллах тухай зөвлөлдөх уулзалт
Жендерийн тэгш байдлын талаарх судалгаануудын танилцуулга	Улаанбаатар 12 сарын 9 Э.Отгончулуун	Жендерийн тэгш байдлын талаарх Нийгмийн ажлын хөгжлийн төв, УСГ, ХЭҮТ мөн ХЭХТ-өөс хийгдсэн судалгаануудын танилцуулга

Олон улсын хурал, семинар

Хурал зөвлөгөөн сургалт семинарын нэр	Хаана хэзээ хэн оролцсон	Гол асуудлууд
Хүний эрхэд ээлтэй сургууль төслийн удиртгал уулзалт	С.Ганчимэг А.Отгончимэг 2 сарын 14-16 Лондон	Төслийн төлөвлөлт, хэрэгжилт, хяналт, удирдамж
ОУ-ын Дарга нарын болон Захирлуудын хамтарсан хурал	Р.Янжмаа Б.Алтантуяа 3 сарын 11- Морокко	2010-16 оны стратеги төлөвлөлт, шилжилтийн үеийн менежмент
Бизнес ба хүний эрхийн өмгөөлөл	Н.Энхчимэг 7 сарын 13-20 Тайланд	Хүний эрх ба компаний нийгмийн хариуцлага, үндэстэн дамнасан корпорацид хамаарах хүний эрхийн өмгөөлөл
Эмнэсти Интернэшнлийн Ази Номхон Далайн Бүсийн кампанит ажлын зохицуулагчдын сургалт	П.Мөнхжаргал Э.Отгончулуун 9 сарын 18-21 Гонконг	“Хүнийг хүндлэ” кампанит ажлын танилцуулга, зориолго, үйл ажиллагааны чиглэл. Мөн кампанит ажлыг хэрхэн амжилттай өрнүүлэх талаар
Ази Номхон Далайн Бүсийн Залуучуудын сүлжээний уулзалт	М.Буянхишиг Б.Батцэнгэл 9 сарын 19-22 Гонконг	Хүнийг хүндэл кампанит ажилд оруулах залуучуудын хувь нэмрийн талаар
Олон Улсын Зөвлөлийн Хурал	Б.Алтантуяа Р.Янжмаа С.Тодгэрэл А.Отгончимэг /Сайн дурын ажилтан/ 8 сарын 7-15 Туркийн Антalia хот	2010-16 оны Уялдаат Стратеги Төлөвлөгөөний төсөл мөн Хүний эрхийн өөрчлөлтийн үр нөлөө юу вэ, Ерөнхий нарийн бичгийн даргын хэлэлцүүлэг, ОУГЗ-ийн болон Санхүүчийн тайлан, Хүнийг Хүндэл кампанит ажлын хэлэлцүүлэг, явц.
Кампани ажлын зохицуулагч нарын уулзалт	Э.Отгончулуун Б.Алтантуяа 11 сарын 16-19 Лондон	2010-2011 онуудад ЭИ байгууллагын хийгдэх ажлуудын төлөвлөгөө, зорилго, зорилтоо тодорхойлох. Гол кампанит ажлуудын багийн танилцуулга, хэлэлцүүлэг
Захирлуудын хурал	Б.Алтантуяа 11 сарын 25-27 Копенгаген Дани улс	Нэн тэргүүнд ажиллах кампанит ажилд нөөц, хүн хүчийг дайчлах
“Эмнэстигийн үр нөлөө 2009” уулзалт	Б.Алтантуяа Ш.Анхмаа Б.Баттогтох Н.Энхчимэг 11 сарын 28 Копенгаген Дани улс	ЭИ-ийн хүний эрхэд оруулсан хувь нэмэр, үр нөлөө ба цаг агаарын өөрчлөлт


МОНГОЛЫН ЭМНЕСТИ ИНТЕРНЭШНЛ БАЙГУУЛАГДСАНЫ 15 ЖИЛИЙН ОЙН

1994 оны 12 дугаар сарын 17-ны өдөр МЭИ байгууллага үүсч байгуулагдсанаас хойш эдүгээ 15 жил болжээ. 15 жилийн ойн баяараа тэмдэглэхээр 2009 оны 12 дугаар сарын 18-ны өдөр МЭИ-ийн үүсгэн байгуулагчид, үе үеийн гишүүд, сайн дурын ажилтнууд хуран цуглаж, МЭИ-ийн 15 жилийн турш хийж бүтээсэн ажлыг мөн түүхийг дэлгэн харуулсан фото зургийн үзүүлбэрийг үзэж сонирхлоо.

Үг үйл ажиллагаанд "ХЭҮК", Франц улсаас Монгол улсад суугаа элчин сайд, "Хорихын байгууллагын нөхөрлөл" –ийн захирал, Сонгогчдын боловсрол төвийн тэргүүн, 7 сарын 1 эвсэл-ТББ-ын ерөнхий зохицуулагч, Хүчирхийллийн эсрэг Үндэсний Төв болон Нийслэлийн Засаг Даргын Тамгийн Газраас төлөөлөл ирж баяр хүргэн мэндчилгээ дэвшүүлсэн нь манай байгууллагын хамтын ажиллагаа өргөжин тэлж буйн нэг илрэл боллоо.

Хүний эрхийн төлөөх үйлсэд сэтгэл зүрх, хуч чадлаа гарган 10 гаруй жил зүтгэсэн үүсгэн байгуулагчид Лу.Болд, С.Эрдэнэцогт, Ц.Монгол, МЭИ-ийн Удирдах Зөвлөлийн даргаар олон жил үр бүтээлтэй ажилласан С.Нарангэрэл нарт МЭИ-ийн "Хүний эрхийн төлөө тэмцэгч" гэсэн батламж гардуулав. Түүнчлэн Хүний эрхийн төлөө оруулсан идэвхи зүтгэл, үнэтэй хувь нэмрийг нь үнэлж идэвхитэн гишүүддээ МЭИ-ийн 15 жилийн ойн өргөмжлөл гардууллаа.

Эмнести Интэрнэшилийн ОУНБДНГ, ОУ-ын Гүйцэтгэх Товчоо, ОУ-ын Хөгжлийн Хороо болон секц бүтцүүдээс МЭИ-ийн үүсч байгуулагдсаны 15 жилийн ойд зориулсан 50 гаруй баярын мэндчилгээ илгээсэн байна.



ХЭВЛЭСЭН МАТЕРИАЛ

www.amnesty.mn
цахим хуудас

МЭИ-ийн үйл ажиллагаа, кампанит ажлын талаархи мэдээлэл www.amnesty.mn цахим хуудсан дээр байрлаж, байнга шинэчлэгддэг. “Нэг-Эмнести”- гийн өнгийг бэлэгдэх шар өнгөөр тодруулсан манай мэдээ, мэдээлэл сонирхогчын анхаарлыг улам бүртгэсэн болно.

2009 оны цахим хуудас нь дан ганц мэдээ төдийгүй тус байгууллагаас 2008-2009 онд хэвлэгдэн гарсан ном товхимол, зурагт хуудас бүрэн эхээрээ хэвлэлийн PDF-хувилбараар тавигдсан болно.

The Wire сонин бичиг



Эмнести Интернэшнл байгууллагаас сар тутам Англи, Араб, Франц, Испани дөрвөн хэл дээр гардаг уг сонин бичгийг 1994 оноос эхлэн Монголын Эмнести Интернэшнл эх хэл дээрээ орчуулан гаргаж олны хүртээл болгож байгаа билээ.

2006 оноос эхлэн нэгдсэн хэвлэл захиалгад орсон тул хувь хүн, албан байгууллага захиалан авч унших боломжтой. Жилийн захиалгын үнэ нь 12 фунт стерлинг, 18 ам.доллар, 21 евро байдаг уг сонинг эх хэлээрээ, бас тэгээд ердөө 1600 төгрөгөөр захиалж болно. 2009 оны 1 дүгээр сараас эхлэн эхлэн 2 сар тутамд хэвлэн гаргаж байна. Хэрэв та The Wire хэвлэлийг захиалахыг хүсвэл маркетингийн багт хандаж болох ба ppmteam@am-nesty.org цахим шуудангаар захиалж болно.

Аюулгүй орчин охидын эрх



Энэхүү кампанит ажлын багц хуудас нь “Ягаад би сургуульдаа явжчадахгүй байна вэ”, “Ямар ч алагчлал хүчирхийлэл байх ёсгүй”, “Боловсрол бол ДОХ-оос ангид байх түлхүүр”, “Хулгайлагдсан хүүхэд нас, алдагдсан боловсрол” хэмээх 4 хэсгээс бүрддэг.

Уг товхимолыг дахин хэвлэсэн бөгөөд “Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг таслан зогсооё” кампанит ажлын үеэр гишүүд дэмжигч, Хүний эрхийн чиглэлээрх байгууллагын ажилтнууд, дунд сургуулийн сургач, багш, бодлого боловсруулагчдад зориулан тараагаад байна. Сургууль бол хүүхдийн сурч, хүмүүжих гол орчин билээ. Гэтэл маш олон охид хүчирхийлэл доромжлооос эмээн сургуульдаа айдастай явж байгаа юм. Энэ багц материалд ‘Охидын төлөөх б алхам’-ыг авч хэрэгжүүлэхийгuriалсан уриалга багтсан болно.

Шаардлагад нийцсэн орон байртай байх эрх



24

1948 онд Хүний эрхийн Түгээмэл Тунхаглалыг баталснаар шаардлагад нийцсэн орон байртай байх эрх нь олон улсын болон нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн, нийтээр хэрэгжүүлэх хүний эрхийн тухай эрх зүйд хамарагдах болсон юм. Шаардлагад нийцсэн орон байртай байх эрхийн асуудлаар НҮБ-аас 12-оос доошгүй баримт бичиг батлан тунхагласан байна. Шаардлагад нийцсэн орон байртай байх эрхийн талаарх олон баримт бичигт энэ эрхийг хүн бүрт хамаатай гэж үздэг. Энэ нь маш чухал. Учир нь зарим баримт бичигт шаардлагад нийцсэн орон байртай байх эрхийг тодорхой бүлэгт хамаатай гэж үзсэн байдаг боловч үнэндээ энэ нь дэлхийн аль ч хэсэгт байгаа хүүхэд, эрэгтэй, эмэгтэй бүрт хамаатай эрх юм. Энэхүү эрхийн талаар тодорхой өгүүлсэн номыг Эмнести Интернэшнлээс эрхлэн хэвлүүллээ.

Цагаач ажилтны эрх



21

1990 оны 12 дугаар сард НҮБ-ын Ерөнхий Ассемблей БҮХ ЦАГААЧ АЖИЛТАН БА ТЭДНИЙ ГЭР БҮЛИЙН ГИШҮҮДИЙН ЭРХИЙГ ХАМГААЛАХ ТУХАЙ ОЛОН УЛСЫН КОНВЕНЦИЙГ батлан гаргасан билээ. Энэхүү конвенц нь цагаач ажилтны эрхийг хүлээн зөвшөөрүүлэх, уг эрхийг хамгаалах, хүндэтгэн үзэх талаар тавьж


буй хүчин чармайлтын түүхэн шинэ хуудас нээсэн юм. Энэхүү танилцуулгад цагаач ажилтан ба тэдний гэр бүлийнхний сэтгэлийг түгшээж буй асуудлуудыг ангилан авч үзсэнээс гадна тэдний эрхийг хамгаалахын тулд олон улсын хэмжээнд авч хэрэгжүүлж буй үйл ажиллагааны тухай дурдсан болно.

АСЕАН-ны Тунхаг ба Хүний Эрх Боломж нээв үү эсвэл нүд хуурав уу?



2007 оны 11 дүгээр сард Зүүн Өмнөд Азийн Орнуудын Холбоо (ASEAN) -оос гаргасан ASEAN-ны Тунхаг нь Ази Номхон Далайн бусийн орнуудын анхны гэрээ бөгөөд батлагдсан тохиолдолд улс орнуудад хүний эрхийг хамгаалж, хүндэтгэх үргийг хууль ёсоор хүлээлгэх юм. Уг тунхаг болон сүүлийн жилүүдэд ASEAN-наас батлан гаргасан хүний эрхийн бусад хууль, журам бүрэн хэрэгжвээс бус нутаг дахь иргэний нийгмийн болон бусад байгууллагын Эмнести Интернэшнл машид дэмждэг. Энэхүү мэдээллийн хуудсанд ASEAN-ны Тунхаг хүний эрхийн талаархи заалт, ASEAN-ны хүний эрхийн байгууллагын мандат, суурь, бүрэлдэл зэрэгт баримталж буй Эмнести Интернэшнлийн байр суурийг илэрхийлж байгаа юм. Энэхүү танилцуулгад ASEAN-ны орнуудад тулгарч буй хүний эрхийн тулгамдсан жишээ болох Бирм улсын тухай дурдсан болно.

((ХҮНИЙГ ХҮНДЭЛ))



Дэлхий даяар хүний эрхийн зөрчлөөс үүдэж ядуурал гэгч аюул олон хүний амьдралд нүүрлэжээ. Энэхүү хүний эрхийн зөрчлүүдийн талаар “Хүнийг хүндэл” гарын авлагад дурдсан болно.

Ядуус зөвхөн эд юмаар гачигддагүй. Харин тэд гадуурхагдаж, уг нь үл сонсдох, дарамтанд өртөх аюултай хавханд орсон байдаг. Эрхээ эдлэх нь тэр хавхнаас салгах тулхүүр мөн. Ядуусын хороололд амьдарч буй иргэдийг хамгаалж, жирэмслэлтийн улмаас амь насаа алдах эхийн эндэгдлийг зогсоож, бизнесийн байгууллага, пүс компаниудыг хариуцлагатай болгохын тулд уг ярианаас илүү үйл ажиллагаа чухал байна. Хүнийг бүрэн утгаар нь хүндэлж чадвал хүн бүр нэр төртэй амьдрах, хоол, ус, эрүүл мэнд, боловсрол, орон байрны наад захын үйлчилгээнд хамрагдах эрхээ эдэлнэ. Та ч бас энэ номноос уншиж танилцаарай.

Өөрчлөгдөж буй ертөнц дэх хүний эрхийг хамгаалах нь



Хүн бүр бие даан ганцаараа буюу бусадтай эвлэлдэн нэгдэж, үндэстний болон олон улсын түвшинд хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, хүндэтгэн биелүүлэх явдлыг хөхүүлэн дэмжих түүний төлөө тэмцэх эрхтэй.

Хүний эрхийг хамгаалагчид хувь хүн, нийгэмлэгүүдийг хүн болж төрснийхөө хувьд үндсэн эрхээ шаардахыг уриалж, тэднийг зорижкуулдаг юм. Тэд хүмүүсийг ядуурал, айдас, үл ойшоосон байдалд амьдрахад хүргэж буй ямар ч нийгэм, улс төр, эдийн засгийн бодлогыг хүлээн зөвшөөрдөггүй. Энэ номонд эдгээр зүйлийг агуулсан болно.

Хүний эрх сургалтын Хөтөлбөрт: Математик, Түүх



2004 оны 12 сарын 10 нд НҮБ-аас батлан гаргасан Хүний Эрхийн Боловсролын (ХЭБ) Дэлхийн хөтөлбөрийн дагуу 2005-2009 онуудад Засгийн газрууд бага ба дунд боловсролын хүрээнд ХЭБ-ын хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлэхийг зорилтоо болгосон бөгөөд Эмнести Интернэшнл байгууллага ч энэ зорилтыг дэмжин үйл ажиллагааныхаа нэг гол чиглэл болгон ажиллаж байна. Энэ хүрээнд гаргасан Хүний эрх сургалтын Хөтөлбөрт: Математик, Түүх зэрэг ном нь мэргэжлийн заах арга зүйг шинэ агуулгаар баяжуулж, хичээлийг амьд хичээл болгох, чанартай боловсрол эзэмшүүлэх нөхцөлийг бүрдүүлэхэд ихээхэн ач тус, эрэлт ихтэй байгаагас дахин хэвлэлээ.

Орчин үеийн боолчлол ба хүний наймаа



Далай дамнасан боолын худалдааг устгаж, боолчлох ёсыг халсан тухай түүхийн хичээлээр заадаг. Үнэн хэрэгтээ боолчлол мөхөлгүй шинэ хэлбэрт орж өнөөг хүртэл оршин байгаа нь нууц биш юм.

Хүн худалдах гэмт хэргийг үйлдэж буй зуучлагч, эсвэл элсүүлэгч нар нь орлого багатай айл, өнчин араас нь эрж хайх хүнгүй, хөөцөлдөж явах боломжгүй, гэр булийн

хүчирхийлэлтэй, их дээд сургуулийн оюутнууд, ерөнхий боловсролын сургуулийн төгсөх ангийн охид, эмэгтэйчүүдийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр болон танил тал, нایз нөхдөөр нь дамжуулан олж авдаг.

Энэхүү гарын авлага нь мөн эрэлт хэрэгцээтэй бөгөөд Монголын Эмнести Интернэшнлээс дахин хэвлүүллээ.

Эрхээ эдэлцгээ: Жендэрийн тухай мэдлэгийг дээшлүүлэх сургалтын гарын авлага



Дэлхий дахинд эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг хүний эрхийг бүдүүлэгээр зөрчсөн ичгүүрт хэрэгт тооцдог.

Нийгмийн үнэт зүйлс, хэм хэмжээ, зан төлөв нь нийгэм дэх эрэгтэйчүүд болон эмэгтэйчүүдийн үүрэг, статусыг тодорхойлдог.

Эдгээр ялгаварласан хэм хэмжээ болон үнэт зүйлсийг тэвчих нь эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл гарах замыг нь засдаг үйл явц гэж ойлгож болох юм.

Энэ эмхэтгэлээр жендэрийн талаарх мэдлэгтэй болоход туслах, мэдлэгээ ашиглан цаашид үйл ажиллагаа явуулах түвшинд аваачих байдлаар боловсруулсан болно.

Эмэгтэй хүний эрхийн хамгаалагчид



Эмэгтэй хүний эрхийн хамгаалагчид нь бусдын эрхийг хамгаалах, хүний эрхийг түгээн дэлгэрүүлэхийн төлөө тэмцдэг билээ. Тэд өөрсдийн хийж буй ажил, хэн болохоос хамааран зүй бус хандлагын бай болох нь элбэг.

Засгийн газар эмэгтэйчүүдийг аливаа дарамт хавчлага, айdasгүйгээр үйл ажиллагаа

зохион байгуулах нөхцөлөөр хангах ёстой.

Эмэгтэйчүүд хүчирхийллээс ангид байх үндсэн эрхтэй. Олон улсын эмэгтэйчүүдийн хөдөлгөөн тодорхой амжилтанд хүрч, олон эмэгтэйчүүдийн амьдралыг өөрчилсөн билээ. Бид тэмцэлээрээ эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг зогсоож чадна.

"Би эндээс хаачих вэ?" Монгол Улсад болсон 2008 оны 7-р сарын 1-ний үйл явдлын сургамж



Энэхүү тайланд хүний амь насыг хөнөөх, албадын саатуулах үед эрүүдэн шүүж, бусад хэлбэрээр зүй бусаар харьцсан байж болзошгүй зэргээр шаардлагагүй үед хүч хэтрүүлэн хэрэглэсэн тухай үйлдлийг судалсан. Эрүүдэн шүүсэн, бусад хэлбэрээр зүй бусаар харьцсан байж болзошгүй үйлдлийг сайтар мөрдөн шалгаагүй буюу байлдааны сум хэрэгсэл хэрэглэсэн, хэрэглэх тушаал өгсөн гэж сэжиглэгдэж буй хүмүүст хэрэг үүсгэхгүй, хариуцлага тооцохгүй байгаад Эмнести Интернэшнл санаа зовниж буй өгөөд 2008 оны 7-р сарын 1-ний өдөр гарсан үйл явдлын үр дагаврын асуудлыг гаргаж ирж байна.

САНХҮҮГИЙН ТАЙЛАН


Жилээс жилд Монголын Эмнести Интернэшнл байгууллагын үйл ажиллагаа, цар хүрээ өсөн нэмэгдэж байгаа бөгөөд үүнтэй уялдан санхүүжилт ч өсч байна. Эмнести Интернэшнлийн Олон Улсын Хөгжлийн багаас (ОУХБ) 2009 оны үйл ажиллагаанд зориулж 118258\$-ийн санхүүжилтийг баталсан нь өмнөх оны баталсан төсвөөс 36 хувиар өсчээ.

Мөн онд гадаад хэл дээр хэвлэгдсэн хүний эрхийн талаархи гарын авлага болон тараах материалуудыг эх хэлнээ хөрвүүлэн гаргах зорилго бүхий Азийн хэлний хөтөлбөрийн хүрээнд 7 707 ам. долларын санхүүжилтийг олгосон байна.

2009 онд хүний эрхийг хамгаалах үйл ажиллагааг дэмжигч байгууллагууд болох Английн Эмнести Интернэшнл, Финляндын Эмности Интернэшнл, “Арвай принт”, ХХК, зэрэг байгууллагуудаас Хүний эрхийн боловсрол болон бусад кампанит ажлуудад зориулж нийт 5 648 ам. долларын сан арвижуулалт хийсэн.

Мөн хүний эрхийг хамгаалагч, гишүүд, дэмжигчдийн хандив, тэдний зохион байгуулсан сан арвижуулах үйл ажиллагааны үр дүнд нийт 12 851 ам. долларын сан арвижууллаа. 2009 оны шинэ сан арвижуулалтын төлөвлөгөөний дагуу бүлгүүдээс нийт 1790 ам. долларын сан арвижуулалт, гишүүдийн татвар төлөлтөөс нийт 491 ам. долларын санхүүжилтийг тус тус хийжээ.

2009 оны 12-р сарын 10-ны өдрийн байдлаар нийт 138 255 ам. доллар зарцуулсан бөгөөд үүний 71 хувийг кампанит ажил, хүний эрхийн сургалт зэрэг үйл ажиллагаанд зарцуулсан ба үлдсэн 29 хувийг цалин хөлс, оффиссын болон бусад зардалд тус тус зарцуулсан байна.



Тайлбар:

Дээрхи санхүүгийн тайланг 2009 оны 12-р сарын 10-ний өдрөөр тасалбар болгон бэлтгэв.

2008 ОНЫ ХӨНДЛӨНГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

НББХИБ SM-АУДИТ ХХК

2008 оны 05-р сарын 08-ны өдөр. № 2/47
Улаанбаатар хот.

Монголын Эмнэлийн Интернейшнл байгууллагын удирдлагал

Аудитын дугаалт

Бид Монголын Эмнэлийн Интернейшл байгууллагын 2008 оны 12 сарын 31-ийнхэрх байгууллагын ўлж ажиллагчны мөнгөн хөрөнгийн зарцуулалтын тайлан мэдсэнд нутит хийээз.

Зэгээр санхүүгийн тайлан мэдснийн үзүүн зөвхөгт тус байгууллагын удирдлага хариуцаа. Бидний харууллага бол хийсэн аудитын үндэслэлийн зэгээр санхүүгийн тайлан мэдсэнд дүгнэлт өгөх яадал юм.

Бид аудитав Олон улсын стандартын дагуу явуулна. Санхүүгийн мэдэг, тайллангууд материалын зорчилттай илрүүхийн дээдэйгээдээгүй гэдэг үндэслэлтэй магадлагагаа олж авахын тулд аудитыг төвлөрөж явуулна.

Аудит хийхдээ санхүүгийн мэдэг тайлланын мэдээллийн нотлох шартынг анхан шартын баримтлах санхүүгийн мэдэг лүү хөнгөн шалгах, давтан гүйцэтгэх, исуух аргаар шалгах. Аудит хийх явцад аудиторуудын хамаа тохтоосон үзүүлэлтүүд нь дээрх тайллантуудад дүгнэлт гаргах зохицын үндэсллийн болсон бөгөөд бид дүгнэлтээ дараахи байдвар илрүүхийг байна.


Бид Монголын Эмнэлийн Интернейшл байгууллагын 2008 оны 12 сарын 31-ийнхэрх гаргасан санхүүгийн мэдэг үзүүн зөв илрүүхийгээс байна гэж дүгнэж байна.


 Эс-Эм-
Аудит
ХХК
Захирал III Сүүдээ

[Signature]

Хаяг: Чанчилдийн дүүрэг № төлөөр 15
Аюулгадсан: 209 тогтн
Хаяг: Чанчилдийн дүүрэг № төлөөр 15
Аюулгадсан: 209 тогтн
99060081 99666102

2008 оны санхүүгийн хураангуй тайлан

САЛБАР: МОНГОЛЫН ЭМНЕСТИ ИНТЕРНЕШНЛ		
2008 оны 1 сарын 01-нээж 12 сарын 31	2008 оны 1 сарын 01-нээж 12 сарын 31	
Тасар болсигт	Болсигт	
Санхүүгийн		
Санхүүгийнхээс үлж ажиллагчны орлог	49,304.00	58,476.56
Олон улсын Хадгалсанынс олгоосон санхүүгийн	87,231.00	134,000.20
Олон улсын Хадгалсанынс олгоосон санхүүгийн	9,600.00	10,569.84
ИИМТ САНХҮҮГИЙННИН ДҮН	146,035.00	203,068.62
Зарцуулалт		
Санхүүгийнхээс үлж ажиллагчны зардал	11,490.00	11,663.65
Хурал үзүүлэлтийн зардал	5,740.00	13,625.41
Цэчин хөдөлгөөн зардал	36,845.85	56,710.16
Сэргээхийн зардал	25,000.00	20,000.00
Командыг залж, төслийн жагсаалт ба сувдлыг	56,449.00	60,597.85
Санхүүгийнхээс үлж ажиллагчны зардал	1,637.00	1,991.67
ИИМТ ЗАРДЛЫН ДҮН	135,862.89	134,495.48
Мөнгөн хөрөнгийн зохиц үзүүлэлт	3,881.75	
Азийн зохиц үзүүлэлт		
Өгүүлэх зохиц үзүүлэлт		
Ихэвчийн хөрөнгийн зохиц үзүүлэлт		59,494.89
Ихэвчийн зохиц үзүүлэлт		13,000.00
Өгүүлэх зохиц үзүүлэлт		
ИНГИТ ЗАРДЛЫН ДҮН		
Тайланг боломжруулсан ний-бо:	<i>[Signature]</i>	
Хөхцөн гүйцэтгэх захирал:	<i>[Signature]</i>	
	T. Ариунз Б. Алтантуяа	
Аудит хийсэн аудитор: <i>[Signature]</i>		
О. Чулуунбаатар ("SM аудит" ХХК)		

БИ ТУСЛАХЫГ ХҮСЧ БАЙНА

ИЛҮҮ САЙХАН ДЭЛХИЙ ЕРТӨНЦИЙГ
ЦОГЦЛОН БАЙГУУЛАХЫН ТУЛД
ЭМНЕСТИ ИНТЕРНЭШНЛ ЭЦСИЙН ЦЭГТЭЭ
ХҮРСЭН МӨРГӨЛДӨӨНД Ч ДАЯН ДЭЛХИЙН
МАРТАГДСАН ӨНЦӨГ БУЛАНД Ч ШУДАРГА
ЁС, ЭРХ ЧӨЛӨӨ, НЭР ТӨРИЙГ ХҮН БҮРТ
ОЛГОХЫН ТӨЛӨӨ БҮХ НИЙТИЙГ ХАМАРСАН
АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛЖ ОЛОН НИЙТИЙН
ДЭМЖЛЭГИЙГ БИЙ БОЛГОХЫГ ЭРМЭЛЗЭЖ
БАЙНА

ТА ЮУ ХИЙЖ ЧАДАХ ВЭ?

Хүний эрхийг нухчин дарж буй аюултай хүчнүүдийг хязгаарлах боломжтойг
дэлхий даяарх хүний эрхийг хамгаалагч, дэмжигчид харуулаад байна. Манай
хөдөлгөөнд нэгдэж айdas, эс хонzon авчирч буй хүмүүстэй тэмцэнэ үү.

- Эмнести Интернэшнлд нэгдэж хүний эрхийн зөрчлийг зогсоохын төлөө бүх
нийтийг хамарсан ажил зохион байгуулна уу. Бидэнд өөрчлөлт хийхэд
туслана уу.
- Эмнести Интернэшнлийн ажлыг дэмжиж хандив өргене үү.

БИД ХАМТДАА ДҮҮ ХООЛОЙГОО ХУРГЭЖ ЧАДНА.

Би Эмнести Интернэшнлийн гишүүн болох талаар мэдээлэл авах сонирхолтой
байна.

Нэр:

Хаяг:

Улс орон:

Цахим шуудан:

Би Эмнести Интернэшнлд хандив өргөхийг хүсч байна

Тоо хэмжээ:

Миний Виза карт Мастер карт -аас тооцож авна уу.

Дугаар:

Хугацаа дуусах огноо:

Гарын үсэг:

<http://www.amnesty.mn>

Энэхүү маягтыг өөрийн улс дахь Эмнести Интернэшнлийн салбарт буцааж
илгээнэ үү. Дэлхийн улс орнууд дахь Эмнести Интернэшнлийн салбаруудын
талаарх мэдээллийг дараах цахим хуудаснаас авна уу. Үүнд:
www.amnesty.org/en/worldwide-sites
www.amnesty.mn



ХҮНИЙ ЭРХИЙН ТӨЛӨӨ ХӨРӨНГӨ ОРУУЛЦГААЯ



1500₮



5000₮



2500₮



4000₮



20.000₮



5000, 3500₮



2500₮



8000₮



7000₮



75.000₮



75.000₮